



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Авгад
Даваасүрэн АНХЖАРГАЛ

ИХШХША ДАХЬ ШҮҮХИЙН ЗАРДАЛ, ОНОЛ
ПРАКТИКИЙН АСУУДАЛ



Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн бакалаврын
Зэрэг Горилсон
дипломын Төсөл

Удирдсан:
С.Энхбаяр /Ph.D/

Улаанбаатар. 2026



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Авгад
Даваасүрэн АНХЖАРГАЛ

ИХШХША ДАХЬ ШҮҮХИЙН ЗАРДАЛ, ОНОЛ
ПРАКТИКИЙН АСУУДАЛ



Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн бакалаврын зэрэг
Горилсон дипломын Төсөл

Удирдагч: **С.Энхбаяр /Ph.D/**

Шүүмжлэгч: **Ц.Даваасүрэн /LL.M/**

Улаанбаатар. 2026

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ	i
ТАЛАРХАЛ	ii
ТОВЧ ХУРААНГУЙ	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	vi
ОРШИЛ	1
Сэдэв сонгосон үндэслэл.....	1
Судлагдсан байдал	1
Сэдвийн тулгамдсан асуудал	1
Судалгааны ажлын зорилго, зорилт	2
Судалгааны арга зүй.....	3
Судалгааны шинэлэг тал, ач холбогдол	3
I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ	4
1.1 Шүүхийн зардлын тухай ойлголт.....	4
1.2 Шүүхийн зардал, түүний хууль тогтоомжийн уламжлал.....	6
1.3 Шүүхийн зардлыг нөхөн төлүүлэх хэмжээ, нөхөн төлүүлэхээс чөлөөлөх:.....	15
1.4 Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хуваарилах	19
II БҮЛЭГ. ШҮҮХИЙН ЗАРДЛЫН ПРАКТИК, ТҮҮНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ	21
2.1 Шүүхийн зардлыг тодорхойлсон шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан жишиг, журам	21
2.2 Шинжээчийн зардал, түүний хуваарилалт.....	22
2.3 Гэрч, иргэдийн төлөөлөгчийн зардал.....	23
2.4 Шүүхийн зардалтай холбоотой шүүхийн практикт тулгамдаж байгаа асуудал	25
III БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ХЭСЭГ	37
3.1. Холбооны бүгд найрамдах герман улсын зохицуулалт	37
3.1.1. Шүүхийн зардал.....	37
3.1.2. Шүүхийн зардлын хэмжээг тодорхойлох	38
3.1.3. Шүүхийн зардлаас чөлөөлөх, хэсэгчлэн төлүүлэх	40
3.1.4. Шүүхийн зардлыг хуваарилах.....	42
3.1.5. Шүүхийн зардал төлөх процесс	47
3.2. Бүгд найрамдах казахстан улсын зохицуулалт	50

3.2.1.	Шүүхийн зардал.....	50
3.2.2.	Шүүхийн зардлын хэмжээг тодорхойлох	51
3.2.3.	Шүүхийн зардлаас чөлөөлөх.....	52
3.2.4.	Шүүхийн зардлыг хуваарилах.....	53
3.2.5.	Шүүхийн зардал төлөх процесс	55
ДҮГНЭЛТ		57
САНАЛ.....		60
НОМ ЗҮЙ.....		61

МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, эдийн засгийн их сургууль (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүднээс олон улсын creative commons attribution-noncommercial-noderivs (CC BY-NC-ND) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Нэр: Д.Анхжаргал

Гарын үсэг:

Огноо: 2026/06/04

ТАЛАРХАЛ

Бакалаврын зэрэг хамгаалах энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд мэргэжлийн зөвлөгөө, удирдлагаар хангаж ажилсан удирдагч багш С.Энхбаяр болон хууль зүйн сургуулийн багш нар, хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн зардлын эрх зүйн зохицуулалт, түүний онол, практикт тулгамдаж буй асуудлыг судалсан болно. Судалгаанд шүүхийн зардлын ойлголт, төрөл, нөхөн төлүүлэх зардлын хэмжээ, зардлаас чөлөөлөх болон хуваарилах зохицуулалтыг түүхэн уламжлал, одоогийн хууль тогтоомжийн хүрээнд авч үзсэн. Монгол Улсын ИХШХШтХ-д шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан боловч практикт шинжээчийн зардал зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй гарах зардлыг төлөх механизм тодорхой бус, төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан хэрэг удаашрах, түдгэлзэх нөхцөл үүсэж байна. Мөн гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардлыг нөхөн төлүүлэх ажиллагаа практикт жигд хэрэгжихгүй байгаа нь судалгаагаар илэрч байна. Иймд ХБНГУ болон БНКУ-ын зохицуулалттай харьцуулан, шүүхийн тусгай дансаар дамжуулан зардлыг урьдчилан төвлөрүүлэх, чөлөөлөх болон хэсэгчлэн төлүүлэх шалгуурыг тодорхой болгох, шинжээчийн зардлын төлбөрийн процессыг нарийвчлан хуульчлах шаардлагатай гэж дүгнэв.

Түлхүүр үгс: *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн зардал, нөхөн төлүүлэх зардал, шинжээчийн зардал, гэрч, хэлмэрч, орчуулагчийн зардал*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. 1994 болон 2002 оны ИХШХШТХ-ийн харьцуулалт	12
Хүснэгт 2.1. Дотоод албан томилолтын зардлын хэмжээ	25
Хүснэгт 3.1 Шүүхийн зардлыг хуваарилах зарчим	42
Хүснэгт 3.2 Орон байр чөлөөлөх тухай нэхэмжлэлийн зардал 93б.....	43
Хүснэгт 3.3 Эрх залгамжлан авсан нэхэмжлэлийн зардал 94	44
Хүснэгт 3.4 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөнөөс үүсэх зардал 95	45
Хүснэгт 3.5 Татгалзал (хамгаалалт)-ын арга хэрэгслийн зардал 96.....	45
Хүснэгт 3.6 Давж заалдах шатны ажиллагааны зардал 97	46
Хүснэгт 3.7 Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардал 98	46
Хүснэгт 3.8 МРП-ийн хэмжээ болон Монгол төгрөгийн харьцуулалт	53

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээ.....	17
Зураг 1.2. Шүүхийн зардлын төрөл.....	18
Зураг 2.1. Шүүхийн нийт зардлын хувь хэмжээ	31
Зураг 2.2. ШЕЗ-ийн 2022 оны төсвийн бараа, үйлчилгээний зардал	31
Зураг 2.3. ШЕЗ-ийн 2023 оны төсвийн бараа, үйлчилгээний зардал	32
Зураг 2.4. ИХШХША дахь шинжилгээний төрөл	33
Зураг 2.5. ИХШХША дахь шинжээчийг томилсон байгууллага	33
Зураг 2.6. ИХШХША дахь шинжээч томилсон маргааны төрөл.....	34
Зураг 2.7. Иргэний хэргийн үлдэгдэл.....	34

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ**Товчлол**

БНКУ

БНМАУ

ЕХ

ЗХШХША

ЗХШХШТХ

ИХШХША

ИХШХШТХ

УТХ

ХБНГУ

ШТХ

ЭХХША

ЭХХШТХ

РКН

Тайлбар

Бүгд Найрамдах Казахстан Улс

Бүгд Найрамдах Монгол Ард Улс

Европын холбоо

Захиргааны хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх ажиллагааЗахиргааны хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хуульИргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх
ажиллагааИргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх
тухай хууль

Улсын тэмдэгтийн хураамж

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Шинжээчийн тухай хууль

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх
ажиллагааЭрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай
хуульProzesskostenhilfe (шүүхийн зардлын
туслалцаа үзүүлэх)

ОРШИЛ

Сэдэв сонгосон үндэслэл

ИХШХША дахь шүүхийн зардлыг ИХШХШТХ-ийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт “Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ.”, мөн 52.2 дахь хэсэгт “Шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” Гэж тус тус зохицуулжээ. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй явуулахын тулд шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх зорилготой. Шүүх шүүхийн зардлыг урьдчилан улсын төсвөөс төлж, нэхэмжлэлийн шаардлага хангагдсан хэмжээгээр талуудаар нөхөн төлүүлэхээр хуульчилсан. Практикт уг заалтууд нь хэрхэн хэрэгжиж байгааг судлах, практикт тулгарч буй асуудлыг тодорхойлж, ХБНГУ, БНКУ зэрэг улсуудын хууль тогтоомжтой харьцуулан судлах хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Судлагдсан байдал

Шүүхийн зардлын талаар нарийвчилсан судалгаа хийгдээгүй хэдий ч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэг бүрдэл хэсэг тул судлаачид гол төлөв Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн болон тулгамдсан асуудал сэдэв дор шүүхийн зардлыг хамруулаад дараах байдлаар судалсан байна. Үүнд:

1. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш Д.Хуягийн 2013 онд хуулийн их, дээд сургуулийн сургалт, эрх зүйч, хуульчдад зориулсан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд” сэдэвтэй бүтээлдээ өмгөөлөгчийн хөлсийг шүүхийн зардлын нэг хэсэг болгон хуульчилж, бураатай талаас гаргуулах талаар санаагаа голчлон дэвшүүлжээ.
2. Хуульч Т.Бадрахын 2019 онд нийтэлсэн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал” сэдэвтэй бүтээлд шүүхийн зардлыг нөхөн төлүүлэх системийг халах талаар, энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулахаас гадна, орчин үед хуучирсан арга гэх өнцгөөс саналаа дэвшүүлсэн байна.

Сэдвийн тулгамдсан асуудал

Монгол улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн зардлын талаар дараах тулгамдсан асуудлыг дэвшүүлж байна.

1. ИХШХШтХ-ийн 53 дугаар зүйлд “Нөхөн төлүүлэх шүүхийн зардалд гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлсийг тодорхойлсон боловч, бодит байдалд дээрх зардлуудыг шүүхийн зардлын нэг хэсэг гэж үзэж, зохигчоор нөхөн төлүүлдэг эсэх нь эргэлзээтэй.
2. ИХШХШтХ-ийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэгт “Шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” Гэжээ. Өөрөөр хэлбэл, эхний ээлжид улсын төсвөөс санхүүжүүлж, хэрэг эцэслэн хянан шийдвэрлэгдсэний дараа зохигчоор нөхөн төлүүлэх ёстой. Хэдий хуульчилсан ч төсвийн хязгаарлагдмал байдлаас үүдэн, шүүхийн нийт төсвөөс шинжээч, орчуулагч, хэлмэрч зэрэг зардал маш баг хувийг эзэлдэг тул цөөнгүй хэрэг маргаан нь шүүхийн зардал (шинжээчийн зардал)-ыг төлөөгүйн улмаас төлөгдөх хүртэл буюу тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлсэн хэвээр байна.
3. Шинжээчийн зардлыг нөхөн төлөх холбоотойгоор нөгөө талаас буюу шинжээчийн дүгнэлт гаргасан шинжээч ажлын хөлсөө талуудаас гаргуулах процесс нь маш ерөнхий, ажлын хөлсөө авах хүндрэлтэй байдаг. Шүүх шинжээчийн зардлыг шүүхийн шийдвэр, тогтоолын тогтоол хэсэгт улсын тэмдэгтийн хураамжийг хувиаралддагтай адилаар оруулснаас өөр нарийвчилсан зохицуулалт хуульд тусгагдаагүй байна.
4. Шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх, төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлэх зохицуулалт нь хэт ерөнхий. Өөрөөр хэлбэл, ИХШХШтХ-д төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон гэж ерөнхий тусгасан, ямар нотлох баримт дээр үндэслэх, хүсэлт гаргагч ямар ямар баримт бичгийг бүрдүүлэх нь тодорхойгүй байна. Нөгөөтэйгүүр шүүхийн практикт шүүхийн төсвийн хүрээнд энэ төрлийн хүсэлт хангагдах нь хязгаарлагдмал байх таамаг байна.

Иймд, дээрх асуудлуудыг судлан шинжлэх хэрэгцээ, шаардлага байна.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Судалгааны ажлын хүрээнд тодорхойлсон тулгамдсан асуудлыг нотолж, тодорхойлох, ХБНГУ болон БНКУ-ийн ИХШХША дахь шүүхийн зардлыг хууль тогтоомждоо хэрхэн тусгасан буюу манай оронд тулгамдаж буй асуудлыг дээрх орнууд хууль тогтоомждоо

хэрхэн зохицуулсныг судлахад энэхүү төгсөлтийн ажлын зорилго оршино.

Судалгааны ажлын зорилт

Практикт -д ямар төрлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг, ямар зардлыг зохигчоор гаргуулдаг талаар судлах, Шүүхийн зардлын нэг төрөл болох шинжээчийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхэд тавигдах шаардлага, тухайн шүүхийн байгууллагад энэ талаар дагаж мөрдөгдөж буй дүрэм, журам байгаа эсэх, Шүүхийн зардлын талаар тулгамдаж буйг асуудлыг судалгааны аргуудыг ашиглаж тодорхойлох, ХБНГУ болон, БНКУ-ын хууль тогтоомжид ИХШХША-д шүүхийн зардлыг хэрхэн зохицуулсныг судалж, манай улсын хүрээнд хэрэгжүүлж болох шийдэл, шинэлэг тал байгаа эсэхийг судлах.

Судалгааны арга зүй

- Ярилцлага, асуумжийн арга
- Баримт бичгийн судалгааны арга
- Харьцуулсан судалгааны арга
- Дедукц, индукцийн арга

Судалгааны шинэлэг тал, ач холбогдол

Шүүхийн зардлын талаар нарийвчлан судалсан судалгааны бүтээл, эрдэм шинжилгээний ажил ховор байна. Энэхүү төгсөлтийн ажил нь шүүхийн зардлын онол, практикийн асуудлуудыг тодорхойлж, гадаад орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалснаараа шинэлэг юм.

I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ

1.1 Шүүхийн зардлын тухай ойлголт

“Шүүхийн зардал гэдэг нь хэргийг хянан хэлэлцэх ба шийдвэрлэхтэй холбогдон гарсан зарлага. Иргэний хэрэгт улсын тэмдэгтийн хураамж ба хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлаас бүрдэнэ.¹” гэж Хууль зүйн шинжлэх ухааны доктор С.Нарангэрэл тайлбарлажээ.

“Шүүхийн зардал нь шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр нөлөөтэй явуулах хуулиар тогтоосон санхүүгийн болон эрх зүйн арга хэрэгсэл юм. Хууль зүйн утгаараа шүүхийн зардал гэдэг нь *шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой зайлшгүй гарах зардал* юм.²” гэж З.Мөнхжаргал хуульч тайлбарлажээ.

Монгол Улсын дээд шүүхээс гаргасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарт “Шүүхийн зардал нь өргөн ойлголт бөгөөд шүүхийн төсөв санхүүгийн зарцуулалт, шүүгч, ажилтны цалин хөлс, барилга, цахилгаан, дулаан, унааны зардал зэрэг шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангах, эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулагдах зэрэг олон зардлыг агуулдаг.” гэжээ.

Шүүхийн зардлыг эдийн засгийн тасаас нь тайлбарлах нь:

2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Сангийн сайдын тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-д “Зардал гэж өмчлөлийн хуваарилалтаас үүссэн багасалтаас бусад байдлаар тухайн байгууллагын цэвэр санхүүгийн байдалд гарсан бууралт юм.” гэжээ. Цаашлаад зардлыг ажилтантай холбоотой зардал буюу ажилтны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа, ажил үйлчилгээний зардал, хөрөнгийн элэгдэл, хорогдуулгын зардал, хүүгийн зардал, бусад зардал, гарз, нийгмийн хамгааллын зардал гэж 8 ангилж хэрхэн бүртгэх талаар зохицуулсан байна.

“Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ” гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл шүүхийн зардал гэдэг нь

¹ Содовсүрэнгийн Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, (Улаанбаатар: Адмон, 2008), 579 дэх тал

² Загдын Мөнхжаргал, *Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй Ерөнхий анги*, (Улаанбаатар: Урлах эрдэм, 2009), 226 дахь тал

иргэний хэргийг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах мөнгөн зарцуулалтыг хэлнэ. Шүүхийн зардлыг дотор нь 3 ангилж үзнэ. Үүнд:

- a) иргэний хэрэг шийдвэрлэхтэй холбогдсон зардал;
 - Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, мөн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн дагуу гүйцэтгэсэн ажил нь тэдний үүрэгт ажилд хамаарахгүй³ бол ажлынх нь хөлс;
 - Гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс, гэрчийн мэдүүлгийг очиж авсан зардал;
 - Үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал;
 - Эд мөрийн баримт хадгалуулсны зардал;
 - Шүүхээс нотлох баримтыг бүрдүүлэх явцад гарсан зардал хамаарна.⁴

b) шүүхийн шийдвэр биелүүлэхтэй холбогдож гарсан зардал; Шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой гарсан зардал гэдэг нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг төлбөр төлөгч нь сайн дураар биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч албадан гүйцэтгэхтэй холбоотой гарсан зардал юм. Тухайлбал:

- Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх;
- Эд хөрөнгийг нь битүүмжлэх;
- Барьцаалах, хураах, үнэлгээ тогтоох;
- Хадгалах, худалдан борлуулах зэрэг зардлууд хамаарна.

Шийдвэр гүйцэтгэгч гарсан зардлын баримтыг бүрдүүлж, тэмдэглэл үйлдэх буюу акт бичиж, төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулж, шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд оруулна.⁵

c) улсын тэмдэгтийн хураамж⁶

³ Загдын Мөнхжаргал, *Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй Ерөнхий анги*, (Улаанбаатар: Урлах эрдэм, 2009), 226 дахь тал

⁴ Загдын Мөнхжаргал, *Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй Ерөнхий анги*, (Улаанбаатар: Урлах эрдэм, 2009), 227 дахь тал

⁵ Загдын Мөнхжаргал, *Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй Ерөнхий анги*, (Улаанбаатар: Урлах эрдэм, 2009), 227, 228 дахь тал

⁶ Монгол Улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 156 дахь тал.

Шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой, үйлчилгээ үзүүлсний төлөө зохигчоос төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж гэнэ. Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох, төлөх, хураахтай холбоотой харилцааг “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль”, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-аар зохицуулна.⁷

1.2 Шүүхийн зардал, түүний хууль тогтоомжийн уламжлал

БНМАУ-ын Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль /1926 он/:

БНМАУ-н Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуульд Иргэний, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах журмыг хамтад нь хуульчилж өгсөн бөгөөд энэ нь Монгол Улсад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмыг зохицуулсан анхны нэгдмэл акт байснаараа түүхэн ач холбогдолтой байна. Уг хууль нь 9 бүлэг 111 зүйлтэй.⁸

Тус хуулиас шүүхийн зардлыг зохицуулсан хэсгийг түүвэрлэн авч үзвэл:

- Гуравдугаар бүлгийн дөчин тавдугаар зүйлд “Шүүх таслах газарт тусгай дүрмийн ёсоор хураалгавал зохих аливаа татвар зэргийг хэрэг мэдүүлэхийн хамт төлбөл зохино. Хэрэв үнэхээрийн төлж чадахгүй аваас хэрэг дуусахыг хүртэл татвар хураахыг алгуурлаж болно.”⁹
- Дөрөвдүгээр бүлэг “Заалдагсад, заалдуулагсад ба гэрчийн зэрэг хүмүүсийг шүүх таслах газарт зарлан ирүүлэх тухай”, тавин есдүгээр зүйлд “Аливаа шүүх таслах газар шийтгэх иргэний хэргээс хураах татварын дүрмийн ёсоор гэрч нар ба хэлмэрчийн зэрэг хэрэглэх хүмүүсийн хөлс ба бусад зүйлийн зарлагын хэмжээг харьяат шүүх таслах газар хэрэг шийтгэх тухай бүр тогтоовол зохино.” , жардугаар зүйлд “Дээрх зүйлд дурдсан гэрчийн зэрэг хүмүүст хөлс сүйтгэлийг хэрэг буруудсан этгээд төлбөөс зохих бөгөөд үнэхээрийн хоосон ядуу болох аваас зохих хөлсийг улсын сан ба орон нутгийн захиргааны газраас тавьж олговол зохино.”¹⁰

⁷ Загдын Мөнхжаргал, *Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй Ерөнхий анги*, (Улаанбаатар: Урлах эрдэм, 2009), 231 дэх тал.

⁸ Монгол Улсын Дээд шүүх, *Монголын шүүх Түүхэн хөгжлийн тойм өгүүлэл нийтлэл Хоёрдугаар хэсэг*, 197 дахь тал

⁹ Монгол Улсын Дээд шүүх, *Монголын шүүх Хууль тогтоомжийн эмхтгэл Нэгдүгээр хэсэг*, 2016, 340 дэх тал

¹⁰ Монгол Улсын Дээд шүүх, *Монголын шүүх Хууль тогтоомжийн эмхтгэл Нэгдүгээр хэсэг*, 2016, 341 дэх тал

Явцын дүгнэлт: 1926 оны “Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль”-д улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэгчээр урьдчилан төлүүлэх, улсын тэмдэгтийн хураамжийг нөхөн төлүүлэх, хураамжаас чөлөөлөх үндэслэлийг тусгажээ. Шүүхийн зардалд гэрч, хэлмэрч зэрэг хүмүүсийн хөлсийг авч үздэг байсан бөгөөд тэдгээрийг төлөх зарчмыг тусган хэрэв төлбөрийн чадваргүй бол шүүхийн зардлыг улсын төсөв буюу улсын сан ба орон нутгийн захиргааны газраас санхүүжүүлэхээр тусгаж, шийдвэрлэж байжээ. Хэдий тус хуульд 3 зүйл заалтаар зохицуулсан товчхон боловч үндсэн зарчмыг агуулсан байна.

БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хууль /1952 он/:

Улсын Их хурлын тэргүүлэгчдийн 1952 оны 5 дугаар сарын 27-ны өдөр зарлигаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль батлагдсан. Уг хууль нь 22 бүлэг, 161 зүйлтэй, БНМАУ-ын шүүхийн байгууллагад иргэний хэргийг хянан шийдвэрлэх журмыг тогтоосон, анхны төрөлжсөн хууль юм.¹¹

Энэхүү хуулийн 22 дугаар зүйлээс 29 дүгээр зүйл хүртэл шүүхийн зардлын талаар буюу 22 дугаар зүйлээс 27 дугаар зүйл хүртэл тэмдэгтийн татвар буюу улсын тэмдэгтийн хураамжийн талаар 28 дугаар зүйлээс гэрч, эксперт буюу шинжээчийн зардлын талаар тусгажээ. Үүнд:

Хорин найм. Шүүхээс ажилчин, албан хаагчдыг гэрчээр дуудвал тэдний авдаг цалин нь уул ажиллаж байгаа газраас хэвээр олгогдоно.

Хорин ес. Эксперт нарт төлөх зүйлийг шүүхийн зардлын зүйлд багтаах бөгөөд уул нэхэмжилсэн зүйлийн ёсоор болговол хариуцсан этгээдээс гаргуулна. Харин уул нэхэмжилсэн зүйлийг хэрэгсэхгүй болговол нэхэмжилсэн этгээдээс гаргуулна.¹²

Наян ес. Шийдвэр дотор бичигдвэл зохих зүйл нь:

1. Хэргийг хэзээ хянан шийдвэрлэсэн болох;
2. Шүүхийн бүрэлдэхүүн ба зохигчдын нэрс;
3. Маргалдсан зүйлийг заах;
4. Шүүхээс шийдвэрийг гаргахын үндэслэл ба удирдлага болгож байгаа хууль;
5. Уг хэргийн талаар гаргасан шийдвэрийн утга ба түүнийг гүйцэтгэх журам;

¹¹ Монгол Улсын Дээд шүүх, *Монголын шүүх Түүхэн хөгжлийн тойм өгүүлэл нийтлэл Хоёрдугаар хэсэг*, 198 дахь тал

¹² Монгол Улсын дээд шүүх, *Монголын шүүх Хууль тогтоомжийн эмхтгэл Нэгдүгээр хэсэг*, 2016, 568 дахь тал

6. Гомдол гаргах журам ба шүүхийн зардлыг хэн хэнээр төлүүлэх тухайг шүүхийн шийдвэрт бичнэ.¹³

Явцын дүгнэлт: 1952 оны “БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хууль” нь 1926 оны “Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль”-тай харьцуулахад шүүх байгууллагад иргэний хэргийг хянан шийдвэрлэх журмыг тогтоосон анхны нарийн зохицуулалт тул улсын тэмдэгтийн татвар /УТХ/-ыг илүү нарийн харин шүүхийн зардал болох эксперт нарт төлөх зүйл /шинжээчийн зардал/-г хэрхэн хуваарилахыг тусгаснаараа онцлог байна.

БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хууль /1967 он/:

1960 оны III Үндсэн хуулийн үзэл санааг тусгасан социалист гэх тодотголтой Иргэний байцаан шийтгэх хуулийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын их хурлаас 1967 оны 6 дугаар сарын 29-ны өдөр батлан гаргасан. Уг хууль нь бүтцийн хувьд 6 хэсэг, 39 бүлэг, 313 зүйлтэй.¹⁴

Уг хуулийн долоодугаар бүлэгт шүүхийн зардлыг зохицуулжээ. Үүнд:

71-р зүйл. Шүүхийн зардлын тухай ойлголт

Шүүхийн зардал нь улсын тэмдэгтийн хураамж, энэ хуулийн 73-р зүйлд зааснаар хэрэг хэлэлцэхтэй холбогдон гарсан зардлуудаас бүрдэнэ.

73-р зүйл. Хэрэг хэлэлцэх явдалтай холбогдон гарах зардал

Хэрэг хэлэлцэх явдалтай холбогдон гарах зардалд:

- 1) Гэрч ба шинжээчид төлөх хөлс;
- 2) Газар дээр нь үзлэг явуулахтай холбогдох зардал;
- 3) Тэтгэвэр гаргуулах тухай хэргийн хариуцагчийг эрэн сурвалжлах явдалтай холбогдох зардал;
- 4) Шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбогдсон зардлууд багтана.

74-р зүйл. Шүүхийн зардал төлөх журам

Гэрч ба шинжээч, орчуулагчдад шүүхэд хүрэлцэн ирэх тээврийн ба орон сууц хөлсөлсний зардал, мөн хоногийн зардал төлнө. Шүүхийн даалгавраар гүйцэтгэсэн ажил нь

¹³ Монгол Улсын дээд шүүх, *Монголын шүүх Хууль тогтоомжийн эмхтгэл Нэгдүгээр хэсэг*, 2016, 573 дахь тал

¹⁴ Монгол Улсын Дээд шүүх, *Монголын шүүх Түүхэн хөгжлийн тойм өгүүлэл нийтлэл Хоёрдугаар хэсэг*, 198 дахь тал

хэрэв үүрэгт ажилд нь хамаарахгүй бол шинжээч, орчуулагчид нь даалгавар гүйцэтгэснийхээ төлөө зохих хөлс шагналыг авна.

Гэрчийн хувиар шүүхэд дуудагдан ирсэн ажилчин, албан хаагчдын ажилдаа байгаагүй хугацааны цалин хөлсийг түүний дундаж цалингийн хэмжээгээр бодож ажлын газраас нь олгоно.¹⁵

Гэрч, шинжээчид олгох буюу газар дээр нь үзлэг явуулсны зардлыг төлөхөд зайлшгүй шаардагдах мөнгийг зохих хүсэлт гаргасан зохигч урьдчилан төлнө.

Хэрэв энэхүү хүсэлтийг зохигчид нь хоёулаа гаргасан буюу эсхүл гэрч, шинжээчийг дуудах, газар дээр нь үзлэг явуулах явдал шүүхийн санаачилгаар хийгдсэн бол шаардагдах зардлыг зохигчид тэгш хуваан төлнө.

Гэрч, шинжээч, орчуулагчид төлбөл зохих мөнгийг, тэднийг үүргээ гүйцэтгэсний дараа гэрч, шинжээчийн зардлыг зохигчдоос гаргуулан авсан эсэхийг харгалзахгүй шүүх төлнө. Төлбөр төлөх журам, төлбөрийн хэмжээг хуулиар тогтооно.

Хууль буюу шүүхийн магадлалаар шүүхийн зардал төлөх явдлаас чөлөөлөгдсөн зохигч нь гэрч, шинжээчийн буюу газар дээр нь үзлэг явуулсны зардлыг төлөхгүй.

75-р зүйл. Шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөх

Улсын тэмдгийн хураамж, хэрэг хянан хэлэлцэх явдалтай холбогдон гарсан зардлыг улсын орлогод төлөхөөс чөлөөлөх. Үүнд:

- 1) Прокурорын байгууллага, түүнчлэн бусдын эрх, ашиг сонирхлыг хамгаалахаар хэрэг үүсгэсэн төрийн захиргааны болон улс, хоршоолол, олон нийтийн байгууллага, иргэд;
- 2) Цалин хөлс ба хөдөлмөрийн эрхийн харилцаанаас үүссэн бусад шаардлага гаргасан ажилчин, албан хаагч нэхэмжлэгчид;
- 3) Хөдөлмөр өдрийн буюу ажлын хөлс шагнал нэхэмжилсэн хөдөө аж ахуйн нэгдэл, үйлдвэр хоршооллын артелийн гишүүн нэхэмжлэгчид;
- 4) Зохиогчийн эрх, нээлт, шинэ бүтээл, оновчтой санал гаргах эрхээс үүссэн нэхэмжлэл гаргасан нэхэмжлэгчид;
- 5) Тэтгэвэр төлүүлэх тухай нэхэмжлэл гаргасан нэхэмжлэгчид;

¹⁵ БНМАУ-ын Шүүх яам, *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хуулиуд*, 1980, 451 дэх тал

- 6) Бусдын амь үрэгдүүлсэн, бие махбодод гэмтэл учруулсан буюу өөрөөр эрүүл мэндийг сарниулснаас учирсан хохирлыг арилгуулахаар шаардлага гаргасан нэхэмжлэгчид;
- 7) Эрүүгийн хэрэгтэй хамтатган шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргасан ба таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолд төлбөрийн хэмжээг иргэний шүүн таслах ажиллагааны журмаар тогтоохоор заасны дараа шилжүүлсэн нэхэмжлэлийн, түүнчлэн таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол гаргахдаа нэхэмжлэлийг хэлэлцэхгүйгээр үлдээсэн тухай нэхэмжлэл гаргасан нэхэмжлэгч ба хариуцагч;¹⁶
- 8) Аж ахуйн тооцоон дээр ажилладаггүй, улсын төсвөөр санхүүждэг байгуулга;
- 9) Гомдлоор авч хэлэлцэх хэргийн талаар гомдол гаргасан иргэд ба захиргааны байгууллага;
- 10) Шүүхийн зардал төлөх хөрөнгөгүй учир шүүгчийн тогтоолоор шүүхийн зардлыг улсын орлогод төлөхөөс зохигчид чөлөөлөгдсөн иргэн.

БНМАУ-ын хууль тогтоомжоор эдгээрээс өөр шалтгаанаар шүүхийн зардлыг улсын орлогод төлөхөөс зохигчид чөлөөлөгдөж болно.

Шүүх буюу шүүгч зохигчдын эд материалын байдлыг харгалзан тэдний аль нэгний буюу хоёулангийн шүүхийн зардал төлөх хугацааг хойшлуулах, хэсэглэн төлүүлэх буюу хэмжээг багасгаж болно.

79-р зүйл. Шүүхийн зардал ба өмгөөлөгчид төлөх зардлыг хуваарилах

Нэг зохигчид хэрэг ашигтайгаар шийдвэрлэгдвэл нөгөө зохигч нь шүүхийн зардлыг улсын орлогот төлөхөөс чөлөөлөгдсөн байсан ч шүүх хэрэгт холбогдон гарсан шүүхийн бүх зардлыг түүнээс гаргуулна.

Хэрэв нэхэмжлэлийн хагасыг хангасан бол энэ зүйлд заасан нэхэмжлэлийн шаардлагыг шүүхээс хангасан буюу хангаагүй хэмжээгээр хариуцагч буюу нэхэмжлэгчид хуваарилан хариуцуулна.¹⁷

Энэ зүйлийн заалт нь давж заалдах өргөдөл гаргахад төлсөн улсын тэмдгийн хураамж төлөхөд нэгэн адил хамаарагдана.

Нэг зохигчид хэрэг ашигтайгаар шийдвэрлэгдвэл хэрэгт оролцсон өмгөөлөгчид өгөх зардлыг нэхэмжлэлийн шаардлагын хангагдсан буюу шүүхээс хангахыг татгалзсан хэсгээс

¹⁶ БНМАУ-ын Шүүх яам, *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хуулиуд*, 1980, 452 дахь тал

¹⁷ БНМАУ-ын Шүүх яам, *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хуулиуд*, 1980, 454 дэх тал

түүний 5 хүртэл хувиар бодож нөгөө зохигчоос гаргуулах боловч тогтоогдсон жагсаалтаас хэтрүүлж болохгүй.

Хэрэв дээд шатны шүүх хэргийг шинэчлэн хэлэлцүүлэхгүйгээр шүүхийн анхны шийдвэрийг шууд өөрчилбөл шүүхийн зардлын хуваарийг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.

Зохигчид эвлэрэн хэлэлцэхдээ шүүхийн зардлыг хуваарилах өөр журам тогтоогоогүй бол шүүх энэ зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

80-р зүйл. Шүүхийн зардал ба өмгөөлөгчийн хөлсийг зохигчдод төлөх

Нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзвал хариуцагч нь шүүхийн зардал төлөхгүй. Харин нэхэмжлэгч нь шаардлагаа дэмжээгүй явдал нь хариуцагч өөрийн үүргийг нэхэмжлэл гаргаснаас хойш сайн дураар гүйцэтгэснээс болсон бол шүүх нэхэмжлэгчийн хүсэлтээр шүүхийн зардал ба өмгөөлөгчид төлөх хөлсийг хариуцагчаас гаргуулж болно.

Бусдын ашиг сонирхлыг хамгаалахын тулд хэрэг үүсгэсэн прокурорын байгууллага, түүнчлэн төрийн захиргаа, олон нийтийн байгууллага, иргэдийн гаргасан нэхэмжлэлийг шүүх бүрэн буюу заримыг хангахаас татгалзвал хариуцагчаас гаргасан шүүхийн зардлыг тийнхүү татгалзсан хэмжээгээр төсвийн хөрөнгөнөөс буцаан олгоно.

Энэ хуулийн 41-р зүйлийн гурав дахь ангид зааснаар шүүх хэрэгт татан оролцуулсан хариуцагчид холбогдох нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болговол хэрэг хэлэлцэхтэй холбогдож гарсан зардлыг хариуцагчид төсвийн хөрөнгөнөөс буцаан төлнө.

Битүүмжилсэн эд хөрөнгийг чөлөөлүүлэх тухай нэхэмжлэлийг хангасан бол шүүхийн зардлыг нэхэмжлэгчид төсвийн хөрөнгөнөөс буцаан төлнө.

81-р зүйл. Шүүхийн зардлыг улсад төлөх

Хэрэг хэлэлцэх явдалтай холбогдуулан шүүхээс гаргасан зардал, мөн улсын тэмдгийн хураамжийг төлөхөөс нэхэмжлэгч чөлөөлөгдсөн бол дээрх зардлыг нэхэмжлэлийн шаардлага хангасан хэмжээгээр хариуцагчаас гаргуулж улсын орлогод төлүүлнэ.¹⁸

Нэхэмжлэлийн шаардлагыг хангахаас татгалзсан бол хэрэг хэлэлцэх явдалтай холбогдуулан шүүхээс гаргасан зардлыг нэхэмжлэгч улсын орлогод төлнө.

Хэрэв нэхэмжлэлийн зарим хэсгийг хангасан бөгөөд хариуцагч шүүхийн зардлаас чөлөөлөгдсөн байвал хэрэг хэлэлцэхэд шүүхээс гаргасан зардлыг нэхэмжлэлийн

¹⁸ БНМАУ-ын Шүүх яам, *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хуулиуд*, 1980, 455 дахь тал

шаардлагыг хангаагүй хэмжээгээр шүүхийн зардлаас чөлөөлөгдөөгүй нэхэмжлэгчээс гаргуулж улсын орлого болгоно.

Хэрэв зохигчид шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн бол хэрэг хэлэлцэхэд шүүхээс гарсан бүх зардлыг улс хариуцна.

Тэтгэвэр төлөхөөс зайлсхийсэн этгээдийг олохын тулд эрэн сурвалжилж зарласан бол тийнхүү эрэн сурвалжлахад гарсан зардлыг түүнээс шүүх гаргуулж улсын орлого болгоно.

82-р зүйл. Шүүхийн зардалтай холбогдсон асуудлын талаар гарсан магадлалыг давж заалдах

Шүүхийн зардалтай холбогдсон асуудлын талаар гарсан магадлалд энгийн гомдол гаргах буюу эсэргүүцэл бичиж болно.¹⁹

Явцын дүгнэлт: 1967 оны БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд шүүхийн зардлыг улсын тэмдгийн хураамж болон хэрэг хэлэлцэх явдалтай холбогдон гарах зардал гэж авч үзсэн байна. Өмнөх хуультай харьцуулахад “Улсын тэмдэгтийн татвар”-ыг “Улсын тэмдгийн хураамж” гэж, мөн “нөхөн төлүүлэх” гэх нэр томъёо тусгагджээ. Онцлог тал нь хэрэг хэлэлцэх явалтай холбогдон гарах зардалд тэтгэвэр гаргуулах тухай хэргийн хариуцагчийг эрэн сурвалжлах явдалтай холбогдох зардлыг шүүхийн зардал хэмээн тусгаж, шүүхийн зардалтай холбогдсон асуудлын талаар гарсан магадлалыг давж заалдах талаар зохицуулсан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /1994 он/:

1994 оны 05 дугаар сарын 09-ний өдөр батлагдаж, 1994 оны 07 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” нь нийт арван найман бүлэг, 242 зүйл заалтаас бүрдсэн. Мөрдөгдөж байх хугацаандаа нийт 6 удаа нэмэлт өөрчлөлт орж байсан. Тус хуулийн дөрөвдүгээр бүлэгт шүүхийн зардлын талаар зохицуулсан байна. 1994 оны “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийг одоогийн мөрдөгдөж буй 2002 оны “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-тай харьцуулан авч үзье:

Хүснэгт 1. 1 1994 болон 2002 оны *ИХШХШтХ-ийн харьцуулалт*

¹⁹ БНМАУ-ын Шүүх яам, *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хуулиуд*, 1980, 456 дахь тал

	1994 оны “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”	2002 оны “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”
Шүүхийн зардал	50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэгт “Шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх боловч энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан зардлыг зохигчдоор нөхөн төлүүлж улсын төсвийн орлогод оруулна.”	52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэгт “Шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”
Нөхөн төлүүлэх шүүхийн зардал	51 дүгээр зүйлд дараах зардлыг зохигчдоор нөхөн төлүүлэхээр тусгажээ. Үүнд: 1/шинжээч, орчуулагч /хэлмэрч/-ийн тээвэр, байр, хоолны зардал, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэсэн ажил нь үүрэгт ажилд нь хамаарахгүй бол ажлын хөлс; 2/гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс; 3/үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал; 4/эд мөрийн баримт хадгалуулсны зардал.	53 дугаар зүйлд зохигчоор нөхөн төлүүлэх зардалд 1994 оны хуульд тусгагдсан 4 заалт дээр “гэрчийн мэдүүлгийг очиж авсан зардал”-г нэмж тусгажээ.
Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээг тодорхойлох	52 дугаар зүйлийн 2/ шинжээч, орчуулагч /хэлмэрч/-ийн ажлын хөлсийг дундаж үнэлгээгээр	54 дүгээр зүйлийн 54.1.2 дахь хэсэгт “шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг шүүхээс төлсөн хэмжээгээр” 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт “Зардлыг шүүхээс заасан улсын төсвийн дансанд тушаана.” /Энэ

	1994 оны “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”	2002 оны “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”
		<i>хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i>
Шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх	53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Зохигч төлбөрийн чадваргүй буюу хуульд заасан бусад үндэслэлээр түүнийг шүүхийн зардал нөхөн төлөхөөс шүүхийн шийдвэрээр чөлөөлж болно.”	55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Зохигч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон, эсхүл хуульд заасан бусад үндэслэл байвал, зохигчийг шүүхийн зардал нөхөн төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлж болно.”
	53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэгт “Шүүх тухайн этгээдийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн зардлыг нөхөн төлөх хэмжээг нь багасгах буюу хугацааг хойшлуулах, хэсэгчлэн төлүүлэх эрхтэй. ”	55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт “Шүүх тухайн этгээдийн эд хөрөнгийн болон байдлыг харгалзан шүүхийн зардлыг нөхөн төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж болно. ”
Шүүхийн зардлыг хуваарилах	54 дүгээр зүйлийн 54.3 дахь хэсэгт “Дээд шатны шүүх хэргийг шинэчлэн хэлэлцүүлэхгүйгээр шүүхийн шийдвэрийг өөрчилбөл шүүхийн зардлын хуваарилалтыг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.”	56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт “Хяналтын шатны болон давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилбөл шүүхийн зардлын хуваарилалтыг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.”
	54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт “Нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзвал хариуцагч нь шүүхийн зардлыг нөхөн төлөхгүй. Харин нэхэмжлэгч	56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт “Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзвал хариуцагч шүүхийн зардлыг нөхөн төлөхгүй. Харин хариуцагч нэхэмжлэлийн

	1994 оны “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”	2002 оны “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”
	шаардлагаа дэмжээгүй явдал нь хариуцагч өөрийн үүргийг сайн дураар гүйцэтгэснээс болсон бол шүүхийн зардлыг хариуцагч нөхөн төлнө.”	шаардлагыг сайн дураар хүлээн зөвшөөрч биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан бол хариуцагчийн төлөх шүүхийн зардлыг тавин хувиар хөнгөлнө.”

1.3 Шүүхийн зардлыг нөхөн төлүүлэх хэмжээ, нөхөн төлүүлэхээс чөлөөлөх:

Шүүхийн нөхөн төлүүлэх зардал ба түүний онцлог:

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс гарсан зардлын зарим хэсгийг хуульд урьдчилан зааснаар буюу хэргийн зохигчдоос гаргуулж буй төлбөрийг нөхөн төлүүлэх шүүхийн зардал гэж тодорхойлсон байдаг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухай хэргийн маргааны онцлогоос шалтгаалан шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрч оролцох, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааг явуулж болно. Нөхөн төлүүлэх шүүхийн зардалд шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоол, цалин хөлс хамаардаг.²⁰

а) Шинжээч, орчуулагч, хэлмэрч

Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заасан ажил үүргийг шинжээч, орчуулагч, хэлмэрч гүйцэтгэсний ажлын хөлс, зардлыг шүүх эхний ээлжид төрийн сангаас гаргаж, дараа нь уг зардлыг бүрэн буюу заримыг зохигчоор нөхөн төлүүлэхээр хуулиар зохицуулсан хэдий ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикаас үзэхэд хэргийн зохигч, шинжээч томилуулах хүсэлт гаргахдаа гарах зардлыг өөрөө хариуцахаар үүрэг хүлээх, эсхүл зардлыг бусад зохигчидтой хамтран хариуцах хүсэлт гаргах, шүүх зардлыг хэрхэн хуваарилахыг өөрийн эрх хэмжээгээр тус тус шийдвэрлэдэг. Шүүхээс томилогдсон шинжээч буюу шүүх эмнэлгийн шинжээч, криминалистикийн шинжээч нь үндсэн ажил үүргийн дагуу дүгнэлт гаргасан бол түүнд хөлс олгодоггүй онцлогтой.

²⁰ Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 157 дэх тал.

b) Гэрч

- Дээрх зардлуудаас гадна гэрчийн тээвэр, байр, хоолны зардал нь мөн нөхөн төлүүлэх шүүхийн зардалд хамаарна. Гэрч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчийн үүрэг хүлээж оролцдог бөгөөд ямар нэгэн тодорхой эрх эдэлдэггүй онцлогтой.
- Гэрч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүхийн дуудсан цагт хүрэлцэн ирж мэдүүлэг өгөх боломжгүй байдаг. Тухайлбал; гэрч хүнд өвчтэй байж болно. Ийм нөхцөлд шүүхийн өөрийн зардлаар гэрчийн байгаа газарт очиж мэдүүлэг авч, гарах зардлыг тухайн гэрчийн мэдүүлэг авах хүсэлт гаргасан оролцогчоос нөхөн гаргуулна.
- Гэрч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүхэд ирээгүй бол цагдаагийн байгууллагад түүнийг шүүхэд албадан ирүүлэхийг даалгаж, холбогдох зардлыг гэрчээс өөрөөс нь гаргуулна.

c) Үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулах

Иргэний хэргийн маргааны төрөл, онцлогоос шалтгаалан хэргийн зохигчдын хүсэлтээр үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаанд гарсан зардлыг хэргийн зохигчоос нөхөн гаргуулдаг.

d) Шүүх хэрэгт ач холбогдолтой гэж үзсэн эд мөрийн баримтыг хугацаатай ба хугацаагүйгээр хадгалах ажиллагааг явуулах үүрэгтэй байдаг. Уг үүргийн дагуу эд мөрийн баримтыг хадгалах субъектүүд нь:

- эд мөрийн баримтыг эзэмшигч; баг хорооны засаг дарга; шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба; цагдаагийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан байж болно.

Эдгээр субъектүүд нь эд мөрийн баримтыг хадгалахад гарсан зардлыг тооцоолон нотлон баримтын хамт шүүхэд өгч, шүүх тухайн зардлын тооцоог нягтлан үзсэний үндсэн дээр төрийн сангаас зардлыг гаргуулахаар шийдвэрлэнэ. Уг зардлыг хэргийн зохигчоос нөхөн гаргуулна.²¹

Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээг тодорхойлох:

Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээг тодорхойлоход дараах үндсэн аргуудыг ашиглана.

²¹ Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 158 дахь тал.

- а) **Төрөөс хуульчлан тогтоосон хэм хэмжээ:** Тэтгэврээр амьдардаг, эсхүл тодорхой хугацааны дараа төлбөрийн чадвартай болох хэмжээний хөрөнгө, мөнгөний эх үүсвэртэй болохыг нотолсон баримт, шүүхийн зардлыг төлөх боломжтой болох байдал зэрэг олон нөхцөл байдлаас шалтгаалан шүүх дүгнэлт хийж асуудлыг хуульд нийцүүлэн зохигчийн төлөх шүүхийн зардлын хэмжээг багасгах, төлбөр төлх хугацааг хойшлуулах, төлбөрийг хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэнэ.²²
- б) **Зах зээлийн ханш:** Шинжээч, орчуулагч, хэлмэрч, ажлын хөлсөө өөрсдөө үнэлж, холбогдох баримтаа шүүхэд гаргаж өгнө. Шүүх хөлсийг нь эхэлж тогтоох шаардлагагүй. Харин шинжээч, орчуулагч, хэлмэрчийн шаардаж буй хөлсийг хэргийн бодит байдал, дүгнэлт гаргаж буй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнийн дүн зэргээс шалтгаалан хөлсний хэмжээг шүүх өөрчлөх эрхтэй.
- с) **Урьдчилан тогтоосон цалин, хөлсний хэмжээ:** Хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүхэд дуудагдсан гэрч нь өөрийн нэг цагт авбал зохих цалингийн дунджийг тодорхойлсон баримтыг үндэслэн тухайн гэрч ажлаасаа шүүхэд ирэх, очих хугацаа, гэрчийн мэдүүлэг өгсөн цаг зэргийг нэмж тооцоолон гэрчид олгогдох цалинг шүүх олгохоор шийдвэрлэнэ.²³

Нөхөн төлүүлэх шүүхийн зардал авах субъект, зардлын төрөл, хэмжээ зэргийг зураглан харвал:

Зураг 1.1. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээ




Эх сурвалж: Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 161 дэх тал

²² Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 159 дэх тал.

²³ Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 160 дахь тал.

Зураг 1.2. Шүүхийн зардлын төрөл



Эх сурвалж: Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 161 дэх тал

Шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх:

Шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх агуулга нь дараах хоёр бүрэлдэхүүнтэй.

Үүнд:

- Шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс бүрэн чөлөөлөх:

Зохигч шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөгдөх үндэслэл нь тухайн шүүхэд зохигч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар, нотлох баримтаар тогтоогдсон хүсэлт юм. Уг үндэслэлийн ард ИХШХШТХ-ийн 4 дүгээр зүйлд зааснаар хэргийн зохигчид шүүхийн өмнө тэгш эрхтэй байх, мөн хуулийн 6 дугаар зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа мэтгэлцэх зарчмаар явагдахаар заасан зарчмууд агуулагдаж байгаа бөгөөд шүүх хэргийн зохигчдын шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх асуудлыг санаачилгаараа шийдвэрлэх боломжгүй юм. Иймээс шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлүүлэх талаар хэргийн зохигчоос шүүхэд гаргасан хүсэлт, энэ талаар нотолсон баримтыг хавсаргаж өгөх үүргийг хүлээнэ.²⁴

²⁴ Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 162 дахь тал.

- Шүүх тухайн этгээдийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн зардлын хэмжээг багасгах, хугацааг хойшлуулах, төлбөрийг хэсэгчлэн төлүүлэх:

Хэргийн зохигч дээрх үндэслэлээр шүүхэд бичгээр хүсэлт гаргасан байх, хүсэлт гаргах болсон үндэслэлээ нотлох баримтаар нотолсон байх нь шүүх шийдвэрлэх үндэслэл болно. Уг хүсэлт нь үндэслэл муутай, баримтаар нотлогдоогүй гэж үзвэл шүүгч зохигчийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон захирамж гаргана. Хэдий зохигчдод шүүхэд гаргасан хүсэлтээ нотолсон ямар нотлох баримт бүрдүүлэх талаар хуульд тодорхой шалгуурыг заагаагүй боловч шүүгч шүүхэд гаргаж буй хүсэлтээ нотлох нь зохигчдын үүрэг юм.

Шүүхийн зардлыг төлөх эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзана гэдэг нь зардал төлөгч хугацаат цэргийн алба хаах, тахир дутуугийн группийн болон тэтгэврээр амьдардаг, эсхүл тодорхой хугацааны дараа төлбөрийн чадвартай болох хэмжээний хөрөнгө, мөнгөний эх үүсвэртэй болохыг нотолсон баримт, шүүхийн зардлыг төлөх боломжтой болох байдал зэрэг олон нөхцөл байдлаас шалтгаалан шүүх дүгнэлт хийж асуудлыг хуульд нийцүүлэн зохигчийн төлөх шүүхийн зардлын хэмжээг багасгах, төлбөр төлх хугацааг хойшлуулах, төлбөрийг хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэнэ.

1.4 Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хуваарилах

Хуульд дараах байдлаар зохицуулсан бөгөөд тэдгээрийн онцлогийг авч үзвэл:

- Шүүхийн зардлыг нэхэмжлэл бүрэн хангагдсан тохиолдолд хариуцагчаар, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэхэмжлэгчээр нөхөн төлүүлнэ.²⁵
- Шүүхийн зардлыг улсын тэмдэгтийн хураамжийн хэлбэрээр урьдчилан нэхэмжлэгчээр төлүүлдэг. Энэ зардлыг хэргийг шийдвэрлэх үед хэрхэн хуваарилах асуудал нь шүүхийн эрх хэмжээний асуудал бөгөөд хэргийн шийдвэрлэлт зардлыг хуваарилахад гол нөлөөтэй. “Монгол улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар (2 дахь хэвлэл), 2008, 164 дэх тал.”
- Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол шүүхийн зардлыг тэр хэмжээгээр хариуцагч буюу нэхэмжлэгчид хуваариалан хариуцуулна.

²⁵ Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 163 дахь тал.

- Хяналтын шатны болон давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилбөл шүүхийн зардлын хуваарилалтыг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.
- Зохигч эвлэрэхдээ шүүхийн зардлыг өөрөөр хуваарилахаар тохиролцоогүй бол шүүх энэ зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.²⁶

Зохигчид шүүхийн зардлыг төлөх талаар нээлттэй тохирох эрхтэйг энэ зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, зохигчид нь шүүхийн зардлыг 50%:50%, 40%:60%, 70%:30% зэргээр чөлөөтэй хуваарилж болно.

- Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзвал хариуцагч шүүхийн зардлыг нөхөн төлөхгүй. Харин хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг сайн дураар хүлээн зөвшөөрч биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан бол хариуцагчийн төлөх шүүхийн зардлыг тавин хувиар хөнгөлнө.²⁷

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзвал хариуцагч шүүхийн зардлыг нөхөн төлөхгүй гэдэг нь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй. Харин хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснөөрөө улсын тэмдэгтийн хураамжийн тал хувиас чөлөөлөгдөх боломжийг хууль тогтоогч баталгаажуулж өгчээ.²⁸

²⁶ Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 163 дахь тал.

²⁷ Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 163 дахь тал.

²⁸ Монгол улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* (2 дахь хэвлэл), 2008, 165 дахь тал.

II БҮЛЭГ. ШҮҮХИЙН ЗАРДЛЫН ПРАКТИК, ТҮҮНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Энэхүү бүлэгт манай улсын шүүхийн практикт ИХШХШтХ-ийн заалтууд хэрхэн хэрэгждэг, түүнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорилоо. Мөн шүүхийн зардлын талаар Монгол Улсад ИХШХШтХ-иас гадна нарийвчлан зохицуулсан журмуудыг шинэчлэн судлах болно.

2.1 Шүүхийн зардлыг тодорхойлсон шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан жишиг, журам

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс доорх журмуудаар шүүхийн зардлыг зохицуулсан байна.

❖ 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 238 дугаартай Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан “Шүүхийн төсвийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-д шүүхийн зардлыг дараах байдлаар ангилжээ. Үүнд:

- Цалин, нэмэгдэл; хангамж, бараа материалын зардал; норматив зардал; эд хогшлын зардал; ажил үйлчилгээний зардал; урсгал засварын зардал; томилолтын зардал; сургалтын зардал; мэдээллийн технологийн үйлчилгээний зардал; ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшуулал;
- **Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал** (шүүхийн цахим платформ түүнд хамаарах системүүдийн хөгжүүлэлтийн зардал, кибер аюулгүй байдлын үнэлгээ, даатгал, зөвлөх үйлчилгээ зэрэг бодлогын үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх зардал)
- **Мэргэжлийн үйлчилгээний зардал** (аудит, орчуулга, оношилгоо, судалгаа, шинжилгээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, шинжээч, орчуулагч, хэлмэрч, томилолтын өмгөөлөгчийн ажлын хөлс, иргэдийн төлөөлөгчийн зардал зэрэг)²⁹

Дээрхээс харвал, мэргэжлийн үйлчилгээний зардалд ИХШХШтХ-ийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт заасан нөхөн төлүүлэх зардал багтаж байна.

Тус журмын гурав дахь зүйлд шүүхийн төсвийг хуваарилах талаар зохицуулжээ. Төсвийн шууд захирагч жилийн төсөв хуваарилах, сар, улирлын хуваарьт өөрчлөлт

²⁹ Шүүхийн ерөнхий зөвлөл, 2024 оны 10 сарын 24-ны 238 дугаар тогтоол, Шүүхийн төсвийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

оруулахад батлагдсан төсөвтөө багтааж үйл ажиллагаагаа явуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад төсвийг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлага үүсэх тохиолдолд төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулах саналаа Төсвийн ерөнхийлөн захирагчид тооцоо, судалгааны хамт сар бүрийн 20-ны дотор цахимаар ирүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулжээ.

- ❖ 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 63 дугаартай Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Автомашины шатахуун зарцуулалтын норм тогтоох тухай” тогтоолд шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газарт мөрдөх автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын нормыг баталсан. Уг нормд автомашины марк, хөдөлгүүрийн багтаамж, үйлдвэрлэгдсэн огноо, түлш, шатахууны төрөл, орон нутаг болон Улаанбаатар хотын замуудад дулааны болон хүйтний улирал гэж хувааж автомашины шатахууны хэмжээг литрээр журамласан байна. Жишээ нь 2694 хөдөлгүүрийн багтаамжтай, 2011-2013 оны хооронд үйлдвэрлэгдсэн, АИ-92 шатахуун хэрэглэдэг Toyota Land Cruiser Prado-150 маркийн автомашины хувьд дулааны улиралд 100 км тутамд 15 л, хүйтний улиралд 1 дүгээр бүс буюу 9.11-2.15 хооронд 18.8 л + 25% байхаар тусгасан байна.

Шинжээч, хэлмэрч, орчуулагч, иргэдийн төлөөлөгчийн зардал нь шүүхийн зардлын аль бүрэлдэхүүн хэсэг болохыг журамлаж, автомашины түлшний зардлын норм, нормативыг тогтоож өгсөн байна.

2.2 Шинжээчийн зардал, түүний хуваарилалт

Шүүх Шинжээчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд шинжилгээний хураамж, зардал буюу шинжээчийн зардлын талаар тусгажээ. Үүнд:

21.1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 20¹.1-д заасны дагуу зарим төрлийн шинжилгээ хийхэд улсын тэмдэгтийн хураамж авна.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасан шүүх эмнэлгийн шинжилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжгүй Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн урьдчилан төлнө.

21.4.Шинжилгээний байгууллагаас бусад байгууллагад ажиллаж байгаа тусгай мэдлэг бүхий хүнийг шинжээчээр томилон ажиллуулсан тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 53.1.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

хуулийн 44.3.1, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.11 дүгээр зүйлийн 1.1, 2, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлийн 1.1, 11.15 дугаар зүйлийн 1, 2-г заасны дагуу шинжээчийн зардлыг төлнө.

Дээрх зүйл, заалтын дагуу Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зохицуулалтыг авч үзвэл:

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 20¹ дүгээр зүйлд “Зарим шүүх шинжилгээ хийх болон түүнд холбогдох үйлчилгээг үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ”-г заасан байна. Үүнд:

20¹.1.Шүүх шинжилгээний байгууллагад хийгдэх дараах шүүх эмнэлгийн шинжилгээнд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

20¹.1.1.ДНХ-ээр эцэг, эх тогтоох лабораторийн шинжилгээ хийхэд 120,000-180,000 төгрөг

20¹.1.2.хүний шээс, үс, хумс, шүлс, цусанд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис тодорхойлох лабораторийн шинжилгээ хийхэд 45,000-60,000 төгрөг гэх мэт 20¹.1.13 хүртэл хуульчилсан байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан зохицуулалт нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бус эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шинжээчийн зардлын үнийн дүнг тусгасан байна. Тиймээс ИХШХША-нд ШТХ.21.2 дахь хэсэгт заасны дагуу шинжээчийн зардлыг эрүүл мэндийн сангаас санхүүжүүлэх зохицуулалттай байна. Өөрөөр хэлбэл, шүүх шинжилгээний байгууллагаар шинжилгээ хийлгэсэн тохиолдолд шүүх тухайн шинжээчийн зардлыг төлөхгүй бөгөөд харин хэрэг хянан шийдвэрлэгдсэний дараагаар талуудаас нөхөн гаргуулдаг байна.

2.3 Гэрч, иргэдийн төлөөлөгчийн зардал

2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 6/АЗ дугаартай Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, сангийн сайдын хамтарсан тушаалаар “Шүүхийн иргэдийн төлөөлөгчид хөлс болон албан томилолт, замын зардал олгох журам” батлагдсан. Тус журмын хоёр дугаар зүйлд иргэдийн төлөөлөгчид хөлс олгох талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаар мэдээлэл өгсөн, тангараг өргөсөн, хэргийн материалтай танилцсан, шүүх хуралдаанд оролцсон цагийн нийлбэрээр иргэдийн төлөөлөгчийн ажилласан цагийг тооцно.

- Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон ажилласан иргэний шүүхэд ажилласан нэг цагийн хөлсийг нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, шүүх хуралдаан дууссаны дараа бэлнээр болон бэлэн бусаар олгоно.
- Иргэдийн төлөөлөгчийн ажилласан цаг 8 цагаас бага бол ажлын 8 цагаар, 8 цагаас их бол ажилласан цагаар тооцно.
- Иргэдийн төлөөлөгч хэргийн материалтай танилцсан, иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийн талаар мэдээлэл өгсөн, хэргийн материалтай танилцах, шүүх хуралдаанд оролцсон тухай тэмдэглэл, баримтыг үндэслэн тухайн шүүхийн Тамгын газраас энэ журамд зааснаар тооцож хөлс олгоно. Хөлс олгох баримтад шүүгчийн туслах, тухайн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга тус тус гарын үсэг зурна.

Харин иргэдийн төлөөлөгчийн томилолтын болон замын зардлыг дараах байдлаар олгохоор журамласан байна. Үүнд:

- Шүүх байрлаж байгаа орон нутгийн засаг захиргааны нэгжээс алслагдмал зайтай аймаг, сум, баг, хорооноос шүүх хуралдаанд оролцохоор сонгогдсон, мөн шүүх хуралдаан дараагийн өдрүүдэд үргэлжлэхээр болсон тохиолдолд иргэдийн төлөөлөгчид томилолтын болон замын зардлыг шүүхийн Тамгын газар иргэдийн төлөөлөгчийн хүсэлт, холбогдох баримтыг үндэслэн олгоно.
- Сонгогдсон иргэдийн төлөөлөгчийн томилолтын зардлыг (төрийн албан хаагчид) олгох томилолтын зардлын жишгээр тооцно.
- Замын зардлыг нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлсэн тасалбар, тооцооны баримтад үндэслэн олгоно.
- Шүүх байрлаж байгаа аймаг, сумын төвд амьдарч байгаа иргэдийн төлөөлөгчид томилолт, замын зардлыг олгохгүй.
- Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасан зөрчил гаргасан иргэдийн төлөөлөгчид томилолт, унааны зардлыг олгохгүй.
- Нөөцөд сонгогдсон иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааны оролцсон бол түүнд ажилласан цагийн хөлсийг энэ журмын дагуу тооцож олгоно.
- Хуульд заасны дагуу татгалзан гарсан иргэдийн төлөөлөгчид томилолт, замын зардлыг энэ журмын дагуу олгоно.

Мөн уг журмын бусад зүйлд дараах зүйлийг тусгасан байна.

- Тухайн шүүхийн Тамгын газрын жилийн төсвийн төслийг боловсруулахдаа иргэдийн төлөөлөгчийн зардлыг тусгасан байна. Иргэдийн төлөөлөгчийн зардлыг тооцохдоо

тухайн шүүхэд сүүлийн гурван жилийн байдлаар бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэргийн дунджаар тооцож шүүхийн төсвийн төслийг боловсруулна.

- Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон ажилласан иргэний ажлын хөлснөөс холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар тооцно.
- Энэ журамд Шүүхийн ерөнхий зөвлөл, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн сангийн сайдын А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг баталсан.

Хүснэгт 2.1 *Дотоод албан томилолтын зардлын хэмжээ*

	Суманд	Аймгийн төвд	Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод
Хоолны зардал	30,000 төгрөг	40,000 төгрөг	50,000 төгрөг
Байрны зардал	60,000 төгрөг	130,000 төгрөг	150,000 төгрөг

Эх сурвалж: Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/52 дугаар тушаал, “Дотоод албан томилолтын зардлын хэмжээ”, www.judcouncil.mn, (Сүүлд үзсэн: 2026.03.21).

Хэсгийн дүгнэлт: Гэрчийн зардлыг нарийвчлан зохицуулсан зохицуулалт байхгүй тул иргэдийн төлөөлөгчдийн зардлыг зохицуулсан журмыг төсөөтэй хэрэглэх боломжтой байна. Тухайлбал, тус журмын гурав дугаар зүйлд заасан иргэдийн төлөөлөгчдийн томилолтын болон замын зардлыг олгох журмыг хэрэглэж болохоор байна. Уг журмын 3.1-т замын зардлыг олгох үндэслэл, 3.3-т замын зардлыг тооцох үнийн дүн, замын зардлыг олгохгүй байх үндэслэл зэргийг төсөөтэй хэрэглэж болохоор байна. Дээрх хууль, журмуудыг харвал иргэдийн төлөөлөгч, гэрч зардлаа авах процесс, үндэслэл нь шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардалтай харьцуулахад нарийвчилсан зохицуулалт байна.

2.4 Шүүхийн зардалтай холбоотой шүүхийн практикт тулгамдаж байгаа асуудал

Шүүхийн практикт шүүхийн зардлын талаар тулгамдаж буй асуудлыг тодорхойлохын тулд “Баянзүрх Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх” -ийн 10 шүүгчийн туслахаас анкетын арга, 4 шүүгчийн туслахаас ярилцлагын аргаар тус тус судалгаа авсан болно.

1) Анкетын аргыг ашиглан дараах 7 асуултын хүрээнд судалгааг авсан.

Асуулгын үр дүнд:

- Асуулт 1: Шүүхийн шийдвэрт шүүхийн зардлын талаар дэлгэрэнгүй тусгадаг эсэх дээр 90% нь тийм.
- Асуулт 2: Шүүхийн практикт гэрч асуух ажиллагаа хэр их тохиолддог вэ? гэхэд 60% нь хоёр хэрэг тутамд 1 ажиллагаа, 20% нь гурван хэрэг тутамд 1 ажиллагаа, 10% нь таван хэрэг тутамд 1 ажиллагаа, 10% нь арван хэрэг тутамд 1 ажиллагаа.
- Асуулт 3: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдүүлэг өгөхөөр дуудагдсан хугацаанд гэрчийн цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол түүнийг, мөн тээвэр, байр, хоолны зардал шүүхийн зардалд тооцож зохигчидоос гаргуулдаг уу? гэхэд 90% нь үгүй, 10% нь зарим тохиолдолд.
- Асуулт 4: Шүүхийн практикт дараахаас алиныг шүүхийн зардал гэж тооцож зохигчоос гаргуулдаг вэ? гэхэд 4 шүүгчийн туслах шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардлаас илүүтэйгээр тэдгээрийн ажлын хөлсийг гаргуулдаг; 3 шүүгчийн туслах үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал; 2 шүүгчийн туслах өмгөөлөгчийн хөлс; 4 шүүгчийн туслах бусад буюу гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, гэрчийн цалин, хөдөлмөрийн хөлс, үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал, эд мөрийн баримт хадгалах зардал зэргийг шүүхийн зардал гэж тооцож байсан тохиолдол ажиллаж байх хугацаанд нь байхгүй гэх тайлбарыг бичсэн байв.
- Асуулт 5: Шүүхийн практикт шүүхийн зардал нь нэхэмжлэлийн үнийн дүнгээс давсан тохиолдол байдаг уу? гэхэд 40% нь тийм, 60% нь үгүй буюу одоогоор тийм хэрэг байхгүй байгааг бөглөсөн байна.
- Асуулт 6: Шүүхийн зардлыг төлөөгүйгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлсэн хэвээр буюу шинжээчийн дүгнэлт гарсан боловч түүний зардлыг төлж чадахгүй байгаа улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сэргээн явуулахад шинжээчийн зардлыг төлөх хүртэл тодорхойгүй хугацаагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлсэн тохиолдол шүүхийн практикт байдаг уу? гэхэд 6 шүүгчийн туслах тийм, 3 шүүгчийн туслах одоогоор тийм тохиолдол тус шүүгч дээр байхгүй буюу үгүй, 1 шүүгчийн туслах мэдэхгүй гэж хариулжээ.
- Асуулт 7: Шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн тохиолдол гардаг уу? гэхэд 4 шүүгчийн туслах үгүй гэж хариулжээ.

Анкетын аргын дүгнэлт:

1. Шүүхийн практикт гэрч асуух ажиллагаа нь их байдаг боловч мэдүүлэг өгөхөөр шүүхэд дуудагдсан гэрчийн тээвэр, хоол, байрны зардал, цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол тэдгээрийг нөхөн төлүүлэх шүүхийн зардал гэж үзэж, шүүхийн шийдвэрт тусгаж зохигчдоос гаргуулдаггүй.
2. ИХШХШтХ-ийн 53 дугаар зүйлд заасан нөхөн төлүүлэх шүүхийн зардлуудыг шүүхийн практикт зохигчдоос гаргуулсан тохиолдол маш бага байна.
3. Шинжээчийн зардал нь нэхэмжлэлийн үнийн дүнгээс давсан тохиолдолд байдаг. Шинжээчийн зардлыг төлөөгүйгээс тодорхойгүй хугацаагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлсэн хэвээр байгаа тохиолдол байгаа гэж 60 хувь нь хариулсан байна. Мөн дээрх зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлсэн тохиолдол байхгүй гэсэн байна.

2) Ярилцлагын аргаар дараах асуултыг 4 шүүгчийн туслахаас асуув.

Асуулт 1: Шүүхийн практикт гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол тэдгээрийг; шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардлыг шүүхийн нөхөн төлүүлэх зардал гэж үзэж зохигчдоос гаргуулдаг уу? гэхэд 4 шүүгчийн туслах бүгд ажиллаж байх хугацаанд нь тийм тохиолдол гарч байсан удаагүй гэж хариулсан.

Асуулт 2: Зохигчдоос ямар төрлийн зардлыг нөхөн төлүүлдэг вэ? гэхэд шүүгчийн туслахууд шинжээчийн зардал гэв.

Асуулт 3: Дээрх дурдсан зардлуудыг ИХШХШтХ-ийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн дагуу улсын төсвөөс урьдчилан төлж байсан удаа байдаг уу? гэхэд энэ ажиллагаа нь процессын хувьд эхлээд тамгын газар луугаа тоот явуулж асуудаг ч гэсэн шүүхийн төсөв, бусад зүйлсээс шалтгаалан зохигчдоор төлүүлэх тухай хариу ирдэг буюу ажиллаж байх хугацаанд тийм тохиолдол гарч байгаагүй гэж шүүгчийн туслахууд нийтлэг хариулсан. Ялгамжтай хариулсан нь орчуулагч, иргэдийн төлөөлөгчдийн хөлсийг шүүх хариуцдаг бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэггүй, шүүхийн санаачилгаар шинжээч томилсон тохиолдолд улсын төсвөөс санхүүжүүлдэг гэв.

Асуулт 4: Шинжээчийн зардал нь нэхэмжлэлийн үнийн дүнгээс давсан тохиолдолд шүүхийн практикт хэр их байдаг вэ? гэхэд 1 шүүгчийн туслах: “Одоогийн байдлаар ийм тохиолдол байхгүй байна” гэв. 3 шүүгчийн туслах: “Их байдаг”. Гол төлөв хүүхдийн асрамж дээр маргаж байгаа хэрэгт шинжээч томилуулахад тухайн бүс нутаг, давтамжаас

хамаарч зардал нь 700,000-1,000,000 төгрөг болдог, бусад төрлийн хэрэг маргаанд шинжээчийн зардал 200,000-3,000,000 хүртэл болдог. Шүүгчийн туслах 3- “2023.09.12-ны өдрийн “Тэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах, орон сууцыг албадан чөлөөлүүлэх” нэхэмжлэлийн шинжээчийн зардал нь 42,288,600 төгрөг болсон. Зохигчид төлбөрийн чадваргүй гэдгээ нотлох баримтаар нотлоогүй боловч, байнга төлбөрийн боломжгүй гэгцгээдэг. Шинжээчийн зардлыг төлөөгүйн улмаас шинжээч нь шинжээчийн дүгнэлтээ шүүхэд хүргүүлэхгүй байгаа. Шүүх 2 удаа албан тоотоор хүсэлт гаргасан талд шинжээчийн зардлыг төлөх тухай нэхэмжлэх хүргүүлсэн байдаг ч дээр дурдсанчлан ямар нэгэн албан хариу ирээгүй 2024 оноос хойш хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлсэн хэвээр байна.” гэв.

Асуулт 5: ИХШХШТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт заасанчлан шүүхийн зардлын нөхөн төлөх хэмжээг багасгах тохиолдол гарч байсан уу? гэхэд зохигчид нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг 50:50 харьцаатайгаар буюу 50 хувийг зохигчоос, 50 хувийг улсын орлогоос гаргуулах хүсэлт тавьдаг хэдий ч тэгж шийдвэрлэсэн хэрэг ховор байдаг. Одоогийн байдлаар ажиллах хугацаанд ийм тохиолдол гарч байгаагүй гэв.

Асуулт 6: Нийт түдгэлзүүлсэн хэргээс хэд нь шүүхийн зардал буюу шинжээчийн зардлаа төлж чадахгүйн улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлсэн хэвээр байгаа вэ? гэхэд

Шүүгчийн туслах 1: Нийт 6 түдгэлзүүлсэн хэргээс 2 нь ийм шалтгаантай байгаа.

Шүүгчийн туслах 2: Нийт түдгэлзүүлсэн хэргээс 1 нь ийм шалтгаантай байгаа.

Шүүгчийн туслах 3: Нийт 10 түдгэлзүүлсэн хэргээс 2 нь ийм шалтгаантай байгаа.

Шүүгчийн туслах 4: Нийт 10 түдгэлзүүлсэн хэргээс 1 нь ийм шалтгаантай байгаа. гэж тус тус хариулав.

Ярилцлагын аргын дүгнэлт: Шүүхийн практикт гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол тэдгээрийг; шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардлыг шүүхийн нөхөн төлүүлэх зардал гэж үзэж шүүхийн шийдвэрт тусган зохигчдоос гаргуулдаггүй бөгөөд шинжээчийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн тохиолдол маш ховор. Харин орчуулагч, хэлмэрчийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг ч, нөхөн төлүүлэх шүүхийн зардал гэж шүүхийн шийдвэрт тусгаж зохигчдоор нөхөн төлүүлдэггүй, шүүх хариуцдаг боловч хэлмэрч, орчуулагч нар хөлсөө шүүхээс авах процесс удаан гэв. Мөн шинжээчийн зардлыг төлж чадахгүй улмаас, шинжээч дүгнэлтээ шүүхэд ирүүлдэггүй. Үүнээс шалтгаалаад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

шинжээчийн зардал төлөгдөх хүртэл тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлсэн хэвээр байдаг. Нэгдүгээрт хуульд тус зардлыг улсын төсвөөс санхүүжүүлээд хэрэг хянан шийдвэрлэсний дараа нөхөн гаргуулахаар зохицуулсан ч шүүхийн төсөвт тийм хэмжээний мөнгөн хөрөнгө байдаггүй. Хоёрдугаарт. шинжээч томилуулах хүсэлт гаргасан тал урьдчилан төлж, хэрэг хянан шийдвэрлэсний дараа нөхөн төлүүлэхээр тусгасан ч хүсэлт гаргасан тал тус зардлыг төлөх төлбөрийн чадваргүй байх нь илбэг. Энэ тохиолдолд төлбөрийн чадваргүй гэдгээ албан тайлбар, нотлох баримтаар нотолдоггүй тул шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх, нөхөн төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлэх нөхцөл байдал үүсдэггүй. Ийм нөхцөл байдалд хийгдэх ажиллагаа нь гол төлөв шинжээч томилуулах хүсэлт тавьсан тал руу шинжээчийн зардлыг төлөх тухай нэхэмжлэл илгээдэг байна.

3) Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын ахлах нягтлан бодогч Б.Номин-Эрдэнээс дараах асуултын хүрээнд ярилцлага авав.

Практикт ямар төрлийн зардлыг улсын төсвөөс, ямар зардлуудыг хэргийн оролцогч буюу зохигчдоор гаргуулж байна вэ? Энэ талаар тухайн шүүхэд мөрдөгдөж буй дотоод журам байдаг уу?

Хариулт: Шүүхийн зардлыг үндсэн болон нэмэлт гэж ангилдаг. Үндсэн зардалд цалин, нийгмийн даатгал, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгчдийн зардлууд нь ордог бол нэмэлт зардалд шинжээчийн зардал ордог. Орчуулагчийн зардлын тухайд манай шүүх нь тогтсон орчууллагын газруудтай гэрээгээр ажилдаг. Энэ утгаараа үндсэн зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Гэхдээ шинжээчийн зардлыг огт санхүүжүүлдэггүй гэж ойлгож болохгүй. Тодорхой хэмжээгээр санхүүжүүлдэг. Энэ талаар шүүхэд мөрдөгдөж буй ямар нэгэн журам байхгүй. Шинжээчийн зардлын хувьд тамгын газарт хүсэлт ирсэн тухайн үед төсөв байгаа эсэхээс гол төлөв шалтгаалдаг.

Шүүхийн зардлын тусгайлсан данс байдаг эсэх?

Хариулт: Иргэний шүүхийн хувьд түр данс, тусгай данс байдаггүй.

Нийт шүүхийн төсвөөс хэдэн хувь нь шүүхийн зардалд хуваарилагдаж буй талаар тоо баримт, мэдээ өгч болох эсэх?

Хариулт: Үнийн дүн биш, хувиар өгч болно. 2025 оны байдлаар нийт шүүхийн төсвийн 80% нь цалингийн зардал, 10% нийгмийн даатгалын зардал, 4.3% нь байрны

түрээс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 1.5% нь шуудан холбооны зардал, 1.2% нь бичиг хэргийн зардал, 0.8% нь урсгал засварын зардал, 0.6% нь багаж, тоног төхөөрөмж, тавилгын зардал, 0.3% нь тээвэр, шатахууны зардал, 0.3% нь шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал, 1% нь бусад зардал. Сүүлийн 2 жилийн хугацаанд шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардалд хуваарилагдах төсөв харьцангуй багассан.

Дүгнэлт:Тухайн шүүхэд орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгчдийн зардлыг тамгын газрын үйл ажиллагаа гэж үзэж төсвөөс санхүүждэг. Харин шинжээчийн зардлын хувьд нэмэлт зардал гэх утгаараа хүсэлт тамгын газарт ирүүлсэн тухайн үед төсөв байгаа эсэхээс шалтгаалан санхүүжүүлэх асуудал яригддаг. Хэдэн төгрөгийн дотор байвал төсвөөс санхүүжүүлдэг зэрэг үнийн тааз байхгүй буюу энэ талаар тусгайлсан мөрдөгдөж буй журам байхгүй. Шүүхийн тамгын газрын ажилтны өгсөн тоон мэдээллээс харахад шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал асар бага хувийг эзэлж байна. Энэ нь сүүлийн жилүүдэд багасах хандлагатай байгааг шүүхийн тамгын газрын ажилтан дурдаж байна.

4) Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын ахлах нягтлан бодогч Х.Баярсайханаас дараах асуултын хүрээнд ярилцлага авав.

1. Практикт ямар төрлийн зардлыг улсын төсвөөс, ямар зардлуудыг хэргийн оролцогч буюу зохигчдоор гаргуулж байна вэ? Энэ талаар тухайн шүүхэд мөрдөгдөж буй дотоод журам байдаг уу?

Хариулт: Иргэдийн төлөөлөгч, орчуулагч, бичиг хэрэг, шатахуун гэх мэт зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлдэг бөгөөд дээрх зардлуудыг зохигчдоор нөхөн төлүүлдэггүй. Харин шинжээчийн зардлын хувьд төлбөрийн чадваргүй тохиолдолд шүүгчийн захирамжийн дагуу төсвөөс санхүүжүүлдэг. Энэ талаар тусгайлсан шүүхэд мөрдөгдөж буй журам байхгүй. Иргэдийн төлөөлөгчийн зардлыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож олгодог.

2. Шүүхийн зардлын тусгайлсан данс байдаг уу? Хариулт: Байхгүй.

3. Нийт шүүхийн төсвөөс хэдэн хувь нь шүүхийн зардалд хуваарилагдаж буй талаар тоо баримт, мэдээ өгч болох эсэх?


Хариулт: Төсвийн байгууллага тул дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй, нийтэд ил шилэн данснаас боловсруулалт хийх боломжтой.

4. Гэрчийн зардлын тухайд тухайн шүүхийн хувьд төвсөөс төлдөг эсэх, энэ талаар нарийн зохицуулалт байдаг эсэх?

Хариулт: Гэрчийн зардлын хувьд манай шүүх нь хотын төвийн дүүргүүдийн хэргийг харьяалан шийдвэрлэдэг тул хөдөө, орон нутаг, алслагдмал гарзаас гэрч асуух нь ховор. Хөдөө орон нутагт байсан гэлээ ч тухайн гэрчийн харьяалалын шүүх рүү шүүхийн даалгавар явуулах, эсвэл шүүхийн цахимжилттай холбоотойгоор цахимаар шүүх хуралд оролцуулж, гэрчийн мэдүүлэг авах зэрэг аргуудыг ашигладаг тул гэрчийн зардлын асуудал яригдах нь их ховор.

Дээрх ярилцлагуудын мэдээллийг график болгон харвал:

Зураг 2.1. Шүүхийн нийт зардлын хувь хэмжээ



Эх сурвалж: Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын ажилтнаас авсан ярилцлага.

5) Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан судалгаа, статистик мэдээлэл

❖ 2023 онд ШЕЗ-ийн “Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал” сэдэвтэй харьцуулсан судалгаанд авагдсан статистик


Зураг 2.2. ШЕЗ-ийн 2022 оны төсвийн бараа, үйлчилгээний зардал



Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл, “Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал” харьцуулсан судалгаа, 2023 он, <https://judcouncil.mn/file/research/14>, (Сүүлд үзсэн: 2026.03.28).

Дээрх мэдээллээс харвал, 2108 буюу бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал нь нийт шүүхийн зардал гэдэгт шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардлаас гадна, өөр төрлийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил орно. Гэтэл үүнд хуваарьлагдаж буй зардал нь 2.42% буюу маш бага хувийг эзэлж байна. Үүнээс хэдэв хувь нь шинжээч, хэлмэрч, орчуулагчийн зардлыг эзэлж буй нь мэдэгдэхгүй байгаа ч нийт төсвийн зардалтай харьцуулахад маш бага хувийг эзлэх нь тодорхой байна.

Зураг 2.3 . ШЕЗ-ийн 2023 оны төсвийн бараа, үйлчилгээний зардал



Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл, “Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал” харьцуулсан судалгаа, 2023 он, <https://judcouncil.mn/file/research/14>, (Сүүлд үзсэн: 2026.03.28).

ШЕЗ-ийн 2022 оны төсвийн төслийн саналыг 135,439,535.5 мянган төгрөгөөр нэмж хүргүүлснийг 56,242,871.2 мянган төгрөгөөр буюу 41,5 хувь (урсгал зардлаас 17,716,814.4 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлаас 38,526,056.8 мянган төгрөг)-иар бууруулан баталжээ. Харин 2023 оны төсвийн төслийн саналыг 296,357,554.7 мянган төгрөгөөр өмнөх оны төсвийн төслийн саналаас нэмж хүргүүлснийг 205,472,307.1 мянган төгрөгөөр буюу 69,3 хувь (34,938,165.1 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлаас 170,534,142.1 мянган төгрөг)-иар бууруулан баталсан байна. (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2023) Үүнээс үзэхэд шүүхийн төсвийг жил ахих бүр танах хандлагатай байна.

Улсын төсөв өсөхийн хирээр гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын орон тоо, өсөх хандлагатай байдаг бол шүүхийн төсөв зөвхөн шүүгчийн цалингийн зардлыг өмнөх оноос бууруулахгүй гэсэн зохицуулалтаар хамгаалагдан бусад зардал нь танагдаж, хүртээмжтэй байдлаар батлагддаггүй хэвээр байна. Түүнчлэн ШЕЗ-ийн цалингийн сан нийт батлагдсан төсвийн 2022 онд 86.28 хувийг, 2023 онд 83.79 хувийг эзэлж байгаа нь өндөр дүнтэй харагдаж байгаа мэт боловч цалин бол шууд хүн амын хэрэглээний зардал юм. (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2023)

❖ Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс гаргасан “Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргах, түүнийг үнэлэх асуудал” сэдэвтэй 2015 оны бодлогын судалгаа

Монгол Улсын хувьд шүүхийн шинжилгээг дагнан хэрэгжүүлдэг төрийн байгууллага болох Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд 4 төрлийн буюу шүүх эмнэлгийн шинжилгээ, криминалистикийн шинжилгээ, хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ, эдийн засгийн шинжилгээ гэсэн төрлөөр 50 гаруй төрлийн шинжилгээг хийдэг. Бусад төрлийн шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэж байна.

Энэхүү судалгааны хүрээнд 151 шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд түүвэрлэсэн судалгааг дараах байдлаар хийжээ.

Зураг 2.4. ИХШХША дахь шинжилгээний төрөл



Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл, “Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргах, түүнийг үнэлэх асуудал” бодлогын судалгаа, 2015 он, <https://www.judcouncil.mn/file/research/14>, (Сүүлд үзсэн: 2026.03.28).

Судалгааны хүрээ дэх 151 хэрэг маргааны 98.1 нь дээрх байдлаар шинжээч томилуулсан байна. Үүнээс шинжилбэл, тухайн хэрэг маргаануудын 64% нь шинжээч томилуулсан бөгөөд үүнээс эд хөрөнгийн үнэлгээ, гарын үсгийн шинэжилгээ, эцэг тогтоолгох шинэжилгээ өндөр хувийг эзэлж байна.

Зураг 2.5. ИХШХША дахь шинжээчийг томилсон байгууллага



Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл, “Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргах, түүнийг үнэлэх асуудал” бодлогын судалгаа, 2015 он, <https://www.judcouncil.mn/file/research/14>, (Сүүлд үзсэн: 2026.03.28).

Судалгааны хүрээнд хөрөнгийн үнэлгээний байгууллага, шүүхийн шинжилгээний байгууллага, болон бусад байгууллагаас шинжээчийг ихэнх тохиолдолд тухайн хүсэлтээс шалтгаалан томилж байна.

Зураг 2.6. ИХШХША дахь шинжээч томилсон маргааны төрөл



Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл, “Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргах, түүнийг үнэлэх асуудал” бодлогын судалгаа, 2015 он, <https://www.judcouncil.mn/file/research/14>, (Сүүлд үзсэн: 2026.03.28).

Шинжээч томилсон захирамж, тогтоолыг маргааны төрлөөр авч үзвэл, гэрээний болон гэр бүлийн холбогдолтой маргаан, гэрээний бус үүрэгтэй холбоотой маргаан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргадаг “Монгол Улсын шүүхийн 2025 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ”-нд иргэний хэргийн үлдэгдэл дараах байдалтай байна.

Зураг 2.7. Иргэний хэргийн үлдэгдэл



Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл, “Монгол Улсын шүүхийн 2025 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ”, 2026.02.12, https://judcouncil.mn/site/news_full/15801, (Сүүлд үзсэн: 2026.03.28)

Бүлгийн дүгнэлт: ИХШХШТХ-ийн 53 дугаар зүйлд заасан нөхөн төлүүлэх зардлуудаас орчуулагч, хэлмэрч, үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагааг явуулахад гарсан зардал, эд мөрийн баримт хадгалах зардал, гэрчийн мэдүүлэг очиж авсан зардлуудыг талуудаас нөхөн гаргуулахгүйгээр төсвөөс санхүүжүүлдэг байна. Харин шинжээчийн зардлыг төлбөрийн чадваргүй тохиолдолд улсын төсвөөс гаргадаг ба ихэнх тохиолдолд үүнд зарцуулах төсөв хомс байна. Шинжээчийн зардлыг хэдий хуульд төсвөөс санхүүжүүлж талуудаар нөхөн төлүүлэхээр зохицуулсан хэдий ч практикт хүсэлт гаргасан тал урьдчилан төлж, хэрэг хянан шийдвэрлэж дууссаны дараагаар нөхөн гаргуулах ажиллагаа явагдаж байна. Шүүхийн практикт шүүхийн зардлыг төлж чадахгүй улмаас хэрэг хойшлох, түдгэлзүүлсэн хэргийг сэргээн явуулах хугацаа тодорхойгүй болж, тайлант жил дуусахад ийм төрлийн хэргүүдийн үлдэгдэл өр болж, шийдэгдэхгүй нэг, хоёр жил болж удсаар байна.

Шүүхийн тамгын газрын ажилтны өгсөн тоон мэдээллээс харахад шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал асар бага хувийг эзэлж байна. Энэ нь сүүлийн жилүүдэд багасах хандлагатай байгааг шүүхийн тамгын газрын ажилтан дурдаж байна. Харин жил бүр тогтмол шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргадаг шүүн таслах ажиллагааны дүн мэдээгээс түдгэлзүүлсэн хэргийн тоо харьцангуй бага байгаа хэдий ч өмнөх үеийнхтэй харьцуулбал өндөр хувиар өсөж байна, мөн хойшлуулсан хэргийн тоон үзүүлэлт өндөр харагдаж байна. Иймд шинжээчийн зардлыг зохигчоор төлүүлэх механизмыг гадаад орнуудтай харьцуулах хэрэгцээ шаардлага байна.

Дээрх судалгааны үр дүнд шүүхийн практикт дараах асуудлууд тулгарч байна. Үүнд:

- шүүхийн зарим нөхөн төлүүлэх зардлыг талуудаас гаргуулдаггүй.
- **Шүүхийн зардлыг нөхөн төлүүлэх зарчим буюу зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх буюу шүүхийн зардлыг төлөх процесс.** ИХШХШТХ-д шүүхийн зардлыг улсын төсвөөс урьдчилан төлж, хэрэг хянан шийдвэрлэгдсэний дараагаар талуудаас нөхөн гаргуулах зохицуулалт нь практикт төдийлөн хангалттай хэрэгждэггүй. Нийт шүүхийн төсвийн ердөө 0,3 хувийг шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал эзэлдэг нь үүнийг нотолж байна. Шүүхийн төсөв өсөж байгаа хэрээр ажилчдын цалин хөлсний зардал өсөж, бусад зардлууд буурах төлөв ажиглагдаж байна. Төсвөөс шинжээчийн зардлыг санхүүжүүлж чадахгүй улмаас шинжээчийн дүгнэлт гарсан хэдий ч дүгнэлтийг шүүхэд ирүүлэхгүй байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулж байна. ИХШХШТХ-д шинжээчийн

зардлыг хүсэлт гаргасан тал урьдчилан төлөх талаар тусгаагүй, буюу энэ нь зөвхөн практикт хэрэгждэг.

- **Шинжээч шинжээчийн хөлсөө авах процесс.** Иргэдийн төлөөлөгч, гэрч, хэлмэрч, орчуулагчийн зардлын талаар эрх бүхий байгууллагаас гаргасан нарийвчилсан эрх зүйн зохицуулалт байна. Харин шинжээчийн хувьд шинжээчийн зардлын талаар мөн ажлын хөлсөө авах нарийн зохицуулалт байхгүй байна.
- **Шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх, төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлэх зохицуулалт.** ИХШХШТХ-д төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон гэж ерөнхий тусгасан, ямар нотлох баримт дээр үндэслэх, хүсэлт гаргагч ямар ямар баримт бичгийг бүрдүүлэх нь тодорхойгүй байна. Нөгөөтэйгүүр шүүхийн практикт шүүхийн төсвийн хүрээнд энэ төрлийн хүсэлт хангагдах нь хязгаарлагдмал гэдэг нь статистик мэдээлэлд тусгасан нийт шүүхийн зардлын 0,3 хувийг орчуулагч, хэлмэрч, шинжээчийн зардал эзэлдэг бөгөөд үүнээс хэдэн хувь нь шинжээчийн зардалд хуваарилагддаг нь тодорхойгүй ч, 0,3 хувиас бага байх нь тодорхой байна. Мөн шүүхийн туслахуудаас авсан судалгааны үр дүнд шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх, хэсэгчлэн төлүүлэх хүсэлтийн хангалт нь бага байдаг.

III БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Бүгд Найрамдах Казахстан Улс нь Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд Казах Социалист Бүгд Найрамдах Улс байсан. 1991 оны 12-р сарын 16-нд задралын дараа тусгаар тогтнолоо зарлаж, ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засаг руу шилжих үйл явц эхэлсэн. Монгол Улс мөн 1990 оны Ардчилсан хувьсгалаар социалист системээс гарч, 1992 оны Үндсэн хуулиар албан ёсоор олон намын ардчилсан тогтолцоонд шилжсэн. Ингэснээр хоёр улс ойролцоо хугацаанд (1990-1991 он) ижил гараанаас нэг намын социалист дэглэмээс зах зээл, ардчиллын руу шилжсэн. Хоёулаа хөгжиж буй орнуудын тоонд багтдаг бөгөөд Дэлхийн банкны ангиллаар дээд дунд орлоготой улсууд юм. Уул уурхай, газрын тос, мал аж ахуйд тулгуурласан эдийн засагтай, хүн амын нягтрал бага, ардчилалд шилжих ижил сорилтууд туулсан. Монгол Улс нь Ром-Германы эрх зүйн бүлд хамаардаг тул энэхүү эрх зүйн бүлийн гол төлөөлөгч болох ХБНГУ-ын туршлагаас судлахаар тус хоёр улсыг сонгосон.

3.1. Холбооны бүгд найрамдах герман улсын зохицуулалт

ХБНГУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь 2005 оны 12 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан бөгөөд нийт 10 ном (Book), 6 бүлэг(Chapter) , 1109 заалтаас бүрдэнэ. Энэхүү хуулийн §91-§100-д шүүхийн зардлын үндсэн зарчим ба хуваарилалт, §101-§107-д нөхөн төлүүлэх журам, нөхөн төлүүлэх зардлын хэмжээг зохицуулсан, §110-§113-д “Security for costs” буюу гадаад этгээдийн гаргасан нэхэмжлэлийн зардлын талаар, §114-§118-д шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх нөхцөлийг тус тус зохицуулсан байна.

3.1.1. Шүүхийн зардал

ХБНГУ-ын хууль тогтоомжид шүүхийн зардал нь улсын тэмдэгтийн хураамж, өмгөөлөгчийн хөлс, шинжээч, орчуулагч, гэрчийн зардал гэж 3 хуваан авч үздэг. Code of Civil Procedure (ZPO- Zivilprozessordnung) буюу ИХШХШтХ-д тус зардлуудыг хэрхэн хуваарилах, нөхөн төлүүлэх зэрэг ерөнхий журмыг хуульчилсан. Харин GKG-Gerichtskostengesetz буюу улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, RVG-Rechtsanwaltsvergütungsgesetz- өмгөөлөгчийн хөлсний тухай хууль, JVEG-Justizvergütungs- und -entschädigungsgesetz шинжээч, хэлмэрч, орчуулагч, гэрч, гуравдагч этгээд, иргэдийн төлөөлөгчийн зардлын тухай хууль зэрэг тус хуулиудаар нарийвчлан зохицуулдаг байна.

Дээрх хуулиуд нь бүгд 2004 онд батлагдсан бөгөөд 1994 оноос хойш шинэчлэгдээгүй хуучирсан, төвөгтэй шүүхийн зардлын тарифуудыг тохируулах, мужуудын ялгаатай байдлыг арилгах зорилгоор “Kostenrechtsmodernisierungsgesetz (KostRMOG)” буюу шүүхийн зардлын эрх зүйн иж бүрэн шинэчлэлийн багцын хүрээнд нэг дор батлагдсан хуулиуд юм. (Bundesgerichtshof, 2004)

Code of Civil Procedure (ZPO- Zivilprozessordnung) буюу ИХШХШтХ-д шүүхийн зардалтай холбоотой зүйл заалтуудыг авч үзье. Тус хуулийн “Title 5- Cost of the proceedings” тав дугаар гарчиг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал”-ийн 91-хэсэгт хуульчилжээ.

3.1.2. Шүүхийн зардлын хэмжээг тодорхойлох

101 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд оролцсонтой холбоотой зардал

(1) Маргааны нэг талыг дэмжих зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон гуравдагч этгээдээс гарсан зардлыг 91-ээс 98 дугаар зүйлд заасан журмын дагуу үндсэн талын эсрэг талаар нөхөн төлүүлнэ. Хэрэв эсрэг тал зардлыг хариуцах үндэслэлгүй бол уг зардлыг тухайн оролцсон гуравдагч этгээд өөрөө хариуцна.

(2) Хэрэв гуравдагч этгээд нь үндсэн талтай хамтран оролцогч (69 дүгээр зүйл)-ийн статустай бол зардлыг 100 дугаар зүйлд заасны дагуу хуваарилна.³⁰

103 дугаар зүйл. Зардлыг тогтоох үндэслэл; Зардал тогтоолгох тухай хүсэлт

(1) Шүүх ажиллагааны зардлыг нөхөн төлүүлэх шаардлага гаргахдаа зөвхөн албадан гүйцэтгэх боломжтой хууль зүйн баримт бичиг (гүйцэтгэх баримт бичиг)-т үндэслэнэ.

(2) Нөхөн төлүүлэх зардлын хэмжээг тогтоолгох тухай хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргана. Хүсэлтэд зардлын тооцоолол, эсрэг талд хүргүүлэх хуулбар, зардлын зүйл бүрийг үндэслэсэн нотлох баримтуудыг хавсаргана.³¹

104 дүгээр зүйл. Зардлыг тогтоох ажиллагаа

(1) Анхан шатны шүүх зардлын хэмжээг тогтоох тухай хүсэлтийг хянан шийдвэрлэнэ. Хүсэлтийг гаргасан өдрөөс эхлэн (эсхүл 105(3)-т зааснаар шийдвэр уншиж сонсгосон өдрөөс) тогтоосон зардалд Германы Иргэний хуулийн (BGB) 247 дугаар зүйлд заасан суурь хүүгээс 5 нэгж хувиар илүү хүү тооцно. Хүсэлтийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хангасан бол шийдвэрийг зардлын тооцооллын хамт эсрэг талд албан ёсоор хүргүүлнэ.

³⁰ Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 101.

³¹ Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 103.

(2) Зардлын зүйлийг үндэслэлтэй гэж үзэхэд түүнийг нотлох баримтаар баталгаажуулсан байхад хангалттай. Өмгөөлөгчийн шуудан, холбооны үйлчилгээний зардалд тухайн өмгөөлөгчийн "зардал гарсан" тухай баталгааг үндэслэнэ. Нэмэгдсэн өртгийн албан татварын (НӨАТ) тухайд хүсэлт гаргагч уг татварыг хасалт хийх боломжгүй гэсэн мэдэгдэл гаргасан бол түүнийг үндэслэл болгоно.

(3) Зардал тогтоох тухай шийдвэрт хуульд заасан хугацаанд гомдол гаргаж болно.³²

105 дүгээр зүйл. Зардлыг тогтоох хялбаршуулсан журам

(1) Хэрэв хүсэлт гаргах үед шүүхийн шийдвэр хараахан албадан гүйцэтгэлд шилжээгүй бөгөөд энэ нь гүйцэтгэх ажиллагааг удаашруулахааргүй бол зардлын хэмжээг тогтоосон шүүхийн захирамжийг үндсэн шийдвэр болон түүний гүйцэтгэх хуулбарт шууд тусгаж болно.

(2) Энэ тохиолдолд зардлын захирамжийг тусад нь хүргүүлэх шаардлагагүй бөгөөд тогтоосон дүнг талуудад мэдэгдэхэд хангалттай. Хэрэв зардлын хүсэлтийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хангаагүй бол зардлыг үндсэн шийдвэрт нэгтгэхгүй.

(3) Хэрэв тал шүүхийн шийдвэр гарахаас өмнө зардлын тооцоогоо ирүүлсэн бол тусад нь хүсэлт гаргах шаардлагагүй; энэ тохиолдолд зардлын тооцоог эсрэг талд шүүхээс албан ёсоор хүргүүлнэ.³³

106 дугаар зүйл. Зардлыг хуваарилах

(1) Шүүх ажиллагааны зардлыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хувь тэнцүүлэн хуваарилах тохиолдолд шүүх эсрэг талд хүсэлтийг хүлээн авснаас **хойш 1 долоо хоногийн дотор** өөрийн зардлын тооцоог ирүүлэхийг шаардана.

(2) Хэрэв заасан хугацаанд зардлын тооцоогоо ирүүлээгүй бол шүүх тухайн талын зардлыг тооцолгүйгээр шийдвэр гаргана. Гэхдээ тухайн тал нөхөн төлүүлэх зардлын шаардлагаа нөхөж гаргах эрхтэй бөгөөд үүнээс үүдэн гарсан нэмэлт зардлыг өөрөө хариуцна.³⁴

107 дугаар зүйл. Нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч өөрчлөлт оруулах

(1) Хэрэв зардлыг тогтоосны дараа шүүхээс нэхэмжлэлийн үнийн дүнг (subject matter value) өөрөөр тогтоосон шийдвэр гаргавал тухайн талын хүсэлтээр зардлын хэмжээг шинэчлэн тогтооно.

³² Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 104.

³³ Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 105.

³⁴ Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 107.

(2) Уг хүсэлтийг нэхэмжлэлийн үнийн дүнг тогтоосон шийдвэрийг хүлээн авснаас хойш 1 сарын дотор шүүхийн тамгын газарт гаргана.

3.1.3. Шүүхийн зардлаас чөлөөлөх, хэсэгчлэн төлүүлэх

114 дүгээр зүйл. Урьдчилсан нөхцөл

(1) Хувийн болон эдийн засгийн нөхцөл байдал (санхүүгийн буюу төлбөрийн чадваргүй)-ын улмаас шүүх ажиллагааны зардлыг төлөх боломжгүй, эсхүл зөвхөн хэсэгчлэн буюу хэсэгчилсэн төлбөрөөр (instalments) төлөх боломжтой талуудад тэдгээрийн гаргасан хүсэлтийг үндэслэн шүүх ажиллагааны зардлын туслахлцаа үзүүлнэ. Ингэхдээ тухайн талын өөрийн үндэслэлээ нотлох арга ашиглахаас өөр арга үлдээгүй бөгөөд илт үндэслэлгүй (frivolous) бус байх ёстой.

Тайлбар- Өөрөөр хэлбэл, хүсэлт гаргасан тал шүүхийн зардлаас чөлөөлөгдөх, хэсэгчлэн төлөхийн тулд төлбөрийн чадваргүйгээс гадна, хөнгөн, үндэслэлгүйгээр цаг хожих зэрэг зайл мэх хэрэглэх эсвэл, маргаангүй үйл баримтыг нотлох зорилгоор үндэслэлээ хамгаалах арга хэрэгсэл (шинжээч томилуулах, гэрч асуух гэх мэт ажиллагаа) хэрэглээгүй байх. Тухайн хамгаалалтын хэрэгслийг ашигласнаараа ялах боломжтой байх зэрэг урьдчилсан нөхцөлийг хангасан байх шаардлагатай байна.

(2) Хэрэв шүүхийн зардлын туслалцаа авахгүй байгаа тал бүх нөхцөл байдлыг нухацтай үнэлсний үндсэн дээр амжилтад хүрэх магадлалтай байсан ч нэхэмжлэл гаргах эсвэл хамгаалалт хийхээс татгалзахаар байвал тухайн нэхэмжлэл эсвэл хамгаалалтыг үндэслэлгүй гэж үзнэ.³⁵

Тайлбар- Хүсэлт гаргагч тал нь нэгэнт тогтоогдсон үйл баримтыг баталгаажуулах, өөрийн мөнгөөр хамгаалалтын арга хэрэгсэл хэрэглэхгүй мөртлөө шүүхийн туслалцаа авч хамгаалах арга хэрэгсэл ашиглахыг шүүх хөнгөмсөг гэж үзнэ. Жишээ нь, хөрштэйгээ 100,000 төгрөг зээлсэн талаар маргахдаа үнийн дүн дээр маргаангүй байхад шүүхийн туслалцаагаар 100,000 төгрөг байсан гэдгийг нотлох зорилгоор шинжээч томилуулах хүсэлтийг шүүх хөнгөмсөг үзнэ.

115 дугаар зүйл. Орлого болон хөрөнгийг зарцуулах (Шүүхийн зардлыг хэсэгчлэн төлөх)

³⁵ Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 114.

(1) Талууд шүүхийн зардлыг төлөхдөө өөрийн орлогыг зарцуулах үүрэгтэй. "Орлого" гэдэгт мөнгөн болон мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх бүх төрлийн ашгийг хамааруулна. Орлогыг тодорхойлохдоо дараах зардлуудыг хасна:

1. Нийгмийн хамгааллын хуулийн (SGB XII) 82(2)-т заасан дүн;
2. Тал болон түүний эхнэр/нөхөр, хамтрагчийн амьжиргааны доод түвшний стандартын дагуу тогтоосон дүн;
3. Орон сууцны түрээс болон халаалтын зардал
4. Тусгай хэрэгцээнд зориулсан нэмэлт тэтгэмжүүд.

(2) Хасалтуудын дараа үлдсэн сарын цэвэр орлогоос ("зарцуулах орлого") сар бүр төлөх хэсэгчилсэн төлбөрийн хэмжээг тогтооно. Сарын төлбөрийн евро бутархай гарвал доош нь бүхэлдэж тооцно. Үлдэх сарын төлбөр нь 10 еврогоос бага байвал сарын төлбөр тогтоохгүй. Хэрэв зарцуулах орлого 600 еврогоос их бол сарын төлбөр 300 евро дээр нэмэх нь 600-аас давсан орлогын хэсэг байна. Нийтдээ дээд тал нь 48 сарын төлбөр төлнө.

(3) Тал нь өөрийн хөрөнгө (assets)-ийг боломжит хэмжээнд зарцуулах ёстой.³⁶

(4) Хэрэв тухайн хүсэлт гаргагчийн 1 сарын төлөх боломжтой үнийн дүнг 4-р үржүүлсэнтэй тэнцүү (4 сарийн үнийн дүн) үнийн дүнгээс шүүхийн зардлын нийт үнийн дүн нь бага бол РКН олгохгүй.

Жишээ нь: 1 сарын төлөх боломжтой үнийн дүн 100,000 төгрөг, 4 сарын төлбөр нь 400,000 төгрөг. Харин шүүхийн зардал нь 350,000 буюу 400,000-аас бага тохиолдолд шүүхийн туслалцаа авахгүй байхаар хуульчилсан байна.

116 дугаар зүйл. Албан тушаалын хувиар оролцогч; Хуулийн этгээд

Дараах этгээдүүдэд хүсэлтийн дагуу туслалцаа үзүүлж болно:

1. Албан тушаалын хувиар хэрэгт оролцож буй этгээд (хэрэв зардал нь захиран зарцуулж буй хөрөнгөөс гарах боломжгүй бол);
2. Герман эсвэл ЕХ-ны гишүүн оронд байгуулагдсан хуулийн этгээд, байгууллагууд (хэрэв зардал гаргахгүй байх нь нийтийн ашиг сонирхолд харшлахаар бол).³⁷

117 дугаар зүйл. Хүсэлт гаргах

(1) Хүсэлтийг тухайн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхэд гаргана. Хүсэлт нь хэргийн агуулгыг товч дурдаж, нотлох баримтыг иш татсан байна. (2) Хүсэлтэд талын хувийн болон эдийн засгийн байдлын (гэр бүл, мэргэжил, хөрөнгө, орлого, санхүүгийн үүрэг) тухай

³⁶ Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 115.

³⁷ Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 116.

нотлох баримтын хамт хавсаргана. Энэхүү мэдээллийг эсрэг талд зөвхөн хүсэлт гаргагчийн зөвшөөрлөөр танилцуулж болно (3) Ажиллагааг хялбарчилж, шуурхай болгох зорилгоор Холбооны хууль зүйн яам нь Bundesrat-н зөвшөөрөлтэйгөөр журмын актаар мэдүүлгийн маягтыг баталж болно. Уг маягт нь 120(2) -н 4 дэх өгүүлбэрт заасан тайлбарыг мөн агуулна. (4) Маягт батлагдсан бол хүсэлт гаргах тал уг маягтыг ашиглана.³⁸

Тайлбар: Bundesrat гэдэг нь ХБНГУ-ийн тогтолцоонд мужуудын оролцоог хангах, мужуудын засгийн газрын гишүүдээс бүрдэх институт юм.

118 дугаар зүйл. Хянан шийдвэрлэх ажиллагаа

(1) Тусгай шалтгаан байхгүй бол шүүх эсрэг талд хүсэлтийн талаар байр сууриа илэрхийлэх боломж олгоно. Эсрэг талын гаргасан зардлыг нөхөн төлөхгүй. (2) Шүүх хүсэлт гаргагчаас өгсөн мэдээллээ нотлохыг шаардах, эрх бүхий байгууллагаас лавлагаа авах эрхтэй. Хэрэв тогтоосон хугацаанд мэдээллээ нотлоогүй бол шүүх туслалцаа үзүүлэхээс татгалзана. (3) Энэ зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан ажиллагааг даргалагч шүүгч эсхүл түүний эрх олгосон шүүх бүрэлдэхүүн хэрэгжүүлнэ.³⁹

3.1.4. Шүүхийн зардлыг хуваарилах

Хүснэгт 3.1 *Шүүхийн зардлыг хуваарилах зарчим*

		ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШТХ
	Ижил тал	Ялгаатай тал	
Шүүхийн зардлыг хуваарилах	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангасан тохиолдолд хариуцагчаар, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэхэмжлэлээр зардлыг төлүүлнэ.	-Хэрэв хариуцагч нэхэмжлэлийг гаргах үндэслэл, шалтгаан байхгүй байсан гэдгээ нотолсон, эсвэл нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд шууд зөвшөөрсөн бол хэрэг хянан шийдвэрлэх	-Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг сайн дураар хүлээн зөвшөөрч биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан бол хариуцагчийн төлөх шүүхийн зардлыг

³⁸ Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 118.

³⁹ Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 118.

		ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШТХ
	Ижил тал	Ялгаатай тал	
	Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол шүүхийн зардлыг тэр хэмжээгээр хариуцагч буюу нэхэмжлэгчид хуваариалан хариуцуулна.	ажиллагааны зардлыг нэхэмжлэгч хариуцна. (Federal Ministry of Justice and Consumer Protection in cooperation with juris GmbH, огноо байхгүй) ZPO §93	тавин хувиар хөнгөлнө. (ИХШХШТХ.56.5)

Дээрх хүснэгтэд шүүхийн зардлыг хуваарилах нийтлэг зарчмыг хоёр улсын хүрээнд ялгаатай болон ижил талын талаар харуулахыг зорьсон. ХБНГУ-ын хувьд дээрх ерөнхий зарчмаас гадна нарийвчлан тусгайлсан хэрэг маргаан дээр дараах байдлаар шүүхийн зардлыг хуваарилахаар хуульчилжээ.

Хүснэгт 3. 1 *Орон байр чөлөөлөх тухай нэхмэжлэлийн зардал 93б*

ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШТХ
Орон сууц чөлөөлүүлэх тухай нэхэмжлэлийг шүүх хангахдаа, Иргэний хуулийн (BGB) 574-574б дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчийн түрээсийн харилцааг үргэлжлүүлэх шаардлага нь нэхэмжлэгчийн хууль ёсны ашиг сонирхолтой харьцуулахад үндэслэлгүй гэж үзсэн боловч нэхэмжлэгч зөвхөн дараа үүссэн нөхцөл байдлын улмаас (Иргэний хуулийн 574 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг) ялсан тохиолдолд шүүх зардлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн нэхэмжлэгчид хариуцуулж болно. Энэ журам түрээсийн харилцааг үргэлжлүүлэх тухай нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэгэн адил үйлчилнэ. Хэрэв орон сууц чөлөөлүүлэх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, Иргэний хуулийн 574-574б дүгээр зүйлийн дагуу түрээсийн	ИХШХШТХ-д энэ талаар зохицуулсан зохицуулалт байхгүй.

ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШТХ
харилцааг үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хариуцагч татгалзлынхаа үндэслэлийг нэхэмжлэгчийн шаардсан даруйд мэдэгдээгүй бол шүүх зардлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцагчид хариуцуулж болно. Энэ журам түрээсийн харилцааг үргэлжлүүлэх тухай нэхэмжлэлийг хангасан тохиолдолд нэгэн адил үйлчилнэ. Хэрэв хариуцагч орон сууц чөлөөлөх шаардлагыг шууд хүлээн зөвшөөрсөн боловч шүүхээс байрыг чөлөөлөх хугацаа олгосон тохиолдолд, хариуцагч нэхэмжлэл гаргахаас өмнө түрээсийн харилцааг үргэлжлүүлэх эсхүл чөлөөлөх боломжит хугацаа олгохыг хүссэн боловч нэхэмжлэгч татгалзаж байсан бол шүүх зардлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн нэхэмжлэгчид хариуцуулж болно.⁴⁰	

Хүснэгт 3. 2 Эрх залгамжлан авсан нэхэмжлэлийн зардал 94

ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШТХ
Эрх залгамжлагч нь шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө хариуцагчид өөрийг эрх залгамжилж байгаа талаар мэдэгдээгүй, нотлох баримтаа гаргаж өгөөгүйгээс болж хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг эсэргүүцэхээс өөр аргагүйд хүрсэн хэмжээгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг нэхэмжлэгч хариуцна. Тайлбар: Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг эсэргүүцэхээс өөр аргагүйд хүрсэн гэдэг нь хариуцагч нь нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд гэж үзэж нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн	ИХШХШТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Эрх залгамжлагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарсан этгээдийн бүх эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.” гэжээ. Эрх залгамжлахтай холбоотой ямар нэгэн зардлын талаар зохицуулалт тус хуульд зохицуулаагүй байна.

⁴⁰ Germany, Code of Civil Procedure (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 93 b.

ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШтХ
эсэргүүцсэн тохиолдлыг ойлгоно. Өөрөөр хэлбэл эрх залгамжлагч нь мөн гэдгийг урьдчилан мэдсэн бол шаардлагыг хүлээн зөвшөөрч, шүүх дээр маргахгүй байх боломжтой байсан гэж үзнэ. Энэ тохиолдолд шүүхийн зардлыг нэхэмжлэгч хариуцна. ⁴¹	

Хүснэгт 3.3 *Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөнөөс үүсэх зардал 95*

ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШтХ
Шүүх хуралдаанд ирээгүй эсвэл тогтоосон хугацааг хэтрүүлсэн тал үүнээс үүдэн гарсан зардлыг хариуцна. Өөрийн буруугаас болж шүүх хуралдааныг хойшлуулах, дахин товлдох, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг сунгах нөхцөлийг бүрдүүлсэн бол энэ заалт нь нэгэн адил хамаарна. ⁴²	ИХШХШтХ-д зохигч, тэдгээрийн төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралд ирээгүй тохиолдолд хэргийг эзгүйд шийдвэрлэх талаар хуульчилсан байдаг. Энэ тохиолдлыг ямар нэгэн шүүхийн зардал гэж үзэхгүй бөгөөд гагцхүү гарах үр дагаврыг зохицуулсан байдаг.

Хүснэгт 3. 4 *Татгалзал (хамгаалалт)-ын арга хэрэгслийн зардал 96*

ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШтХ
Хэдий нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангуулсан эсвэл, бүхэлд нь хэрэгсэхгүй болгож чадсан ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын зүгээс өөрийн шаардлагыг нотлох эсвэл эсрэг талын шаардлагыг няцаахад ашиглаж буй арга хэрэгсэл (гэрч дуудах, шинжээч томилуулах хүсэлт г.м) нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолгүй	ИХШХШтХ-д нарийвчлан зохицуулсан зохицуулалт байхгүй бөгөөд ямар ч тохиолд тус хуулийн 56 дугаар зүйлд заасан шүүхийн зардлыг хуваарилах ерөнхий зарчмыг баримтална.

⁴¹ Germany, *Code of Civil Procedure* (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 94.

⁴² Germany, *Code of Civil Procedure* (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 95.

ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШтХ
байсан бол уг зардлыг тухайн этгээдээр хариуцуулна.⁴³ Тайлбар: Хэдий маргаанд ялсан ч гэлээ албаар тухайн арга хэрэгслийг ашиглаж, зардал зохиомлоор өсгөсөн бол үүнийг өөрөө хариуцах зохицуулалт юм.	

Хүснэгт 3.5 Давж заалдах шатны ажиллагааны зардал 97

ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШтХ
Анхан шатны шийдвэр өөрчлөгдөөгүй тохиолдолд давж заалдах гомдол гаргасан тал шүүхийн зардлыг хариуцна. Хэрэв ялсан тал өмнөх шатны шүүхэд гаргах боломжтой байсан шинэ тайлбар, баримт гаргасны үндсэн дээр давж заалдах шатанд ялсан бол шүүх давж заалдах шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн тухайн ялсан талд хариуцуулна.⁴⁴	ИХШХШтХ-ийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт “Хяналтын шатны болон давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилбөл шүүхийн зардлын хуваарилалтыг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.” заасан байна.

Хүснэгт 3. 6 Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардал 98

ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШтХ
Талууд эвлэрсэн тохиолдолд өөрөөр тохиролцоогүй бол эвлэрлийн зардлыг талууд харилцан тооцож хүчингүй болгосонд тооцно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эвлэрсэн тохиолдолд мөн адил хамаарна. Гагцхүү шүүхийн зардлын тухай эцэслэн хүчин төгөлдөр	ИХШХШтХ-ийн 74 дүгээр зүйлд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, 74¹ дүгээр зүйлд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах ажиллагааг тусгасан. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан

⁴³ Germany, *Code of Civil Procedure* (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 96.

⁴⁴ Germany, *Code of Civil Procedure* (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 97.

ХБНГУ-ын ZPO	МУ-ын ИХШХШтХ
шүүхийн шийдвэр аль хэдийн гарсан бол энэ журам үйлчлэхгүй. ⁴⁵	шийдвэрлэгдсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тал хувиар бууруулж тогтооно. Харин эвлэрүүлэн зуучлагчаас маргааныг зохицуулахтай холбогдон зайлшгүй гарах зардлыг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардал гэнэ. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн зардлыг төсвөөс санхүүжүүлнэ. ⁴⁶

3.1.5. Шүүхийн зардал төлөх процесс

ХБНГУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн зардлыг хүсэлт гаргасан талд зардлын урьдчилгаа төлөх хугацаа зааж өгдөг. Хэрэв заасан хугацаанд мөнгийг тушаахгүй бол шүүх тухайн шинжээчийг томилохоо татгалзах эрхтэй. ZPO-379

Шүүхийн зардлын урьдчилгааг “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль (Justizzahlungsverordnung - JZV)”-ийн 1 дүгээр зүйлд “Шүүхийн бүх төрлийн төлбөр тооцоог (тэмдэгтийн хураамж, барьцаа мөнгө, шинжээчийн хөлс) Шүүхийн касс (Gerichtskasse) гүйцэтгэнэ.” гэж заажээ. Уг дансанд хүсэлт гаргасан тал нь мөнгөн хөрөнгийг байршуулсны дараагаар шүүгчийн захирамжаар шинжээч томилогдоно.

Энэхүү данс нь шүүхийн төсвийн дансаас тусдаа, зөвхөн хэргийн оролцогчдоос шүүхийн төлбөр тооцоог хүлээн авдаг тусгай данс юм. Шинжээч нь шинжээчийн хөлсөө нөхөн төлүүлэх шаардлага гаргахдаа зардлын тооцоог хэрэг хянан шийдвэрлэх явцад буюу шүүхийн шийдвэр гаргахаас өмнө эсвэл шүүхийн шийдвэр гарсны дараа зардлыг тогтоох хүсэлт гаргадаг. Уг хүсэлтийг хэрэг хянан шийдвэрлэгдэж дууссан тохиолдолд анхан шатны шүүхэд гаргахаар ХБНГУ-ын ИХШХШтХ-ийн 103, 104, 105 дугаар зүйлд зохицуулжээ. Шүүхийн зардлын нарийвчилсан зохицуулалт болох , JVEG- Justizvergütungs- und -entschädigungsgesetz шинжээч, хэлмэрч, орчуулагч, гэрч, гуравдагч этгээд, иргэдийн төлөөлөгчийн зардлын тухай хуульд дараах байдлаар зохицуулжээ.

⁴⁵ Germany, *Code of Civil Procedure* (Zivilprozessordnung, ZPO) (2005), Section 98.

⁴⁶ Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг

Тус хуулийн 2 дугаар зүйл. Шаардлага гаргах, эрх дуусгавар болох болон хөөн хэлэлцэх хугацаа.

(1) Ажлын хөлс, нөхөн олговор авах эрх нь тухайн этгээдийг татан оролцуулсан байгууллагад 3 сарын дотор хүсэлт гаргаагүй бол дуусгавар болно. Эрх бүхий этгээдэд энэ хугацаа болон хугацаа тоолох эхлэлийн талаар урьдчилан зааварчилгаа (эрх үүргийг нь сануулах) өгөх ёстой. Хугацааг дараах байдлаар тоолно:

1. Бичгээр шинжээчийн дүгнэлт гаргах эсвэл орчуулга хийх тохиолдолд: Дүгнэлт, орчуулга захиалсан байгууллагад хүргэгдсэн өдрөөс;
2. Шинжээч, гэрчээр мэдүүлэг өгөх эсвэл хэлмэрчээр ажиллах тохиолдолд: Мэдүүлэг өгч дууссан эсвэл оролцоо дуусгавар болсон өдрөөс;
3. Хэрэг гүйцэтгэх ажиллагаа хугацаанаасаа өмнө дуусгавар болсон бол: Энэ тухай мэдэгдсэн өдрөөс;
4. Иргэдийн төлөөлөгчийн хувьд: Бүрэн эрхийн хугацаа дууссан өдрөөс (гэхдээ албан үүргээ гүйцэтгэж дуусахаас өмнө биш).

(2) Хэрэв эрх бүхий этгээд өөрөөс үл хамаарах шалтгаанаар (хүндэтгэн үзэх шалтгаан) хугацаа хоцроосон бол шүүхэд хүсэлт гаргаж, хугацааг сэргээлгэж болно. Хэрэв § 2-ын 1-д заасан зааварчилгаа өгөөгүй бол буруугүй гэж үзнэ. Хугацаа хоцроосноос хойш 1 жил өнгөрсөн бол хугацаа сэргээх хүсэлт гаргах эрхгүй.

(3) Ажлын хөлс, нөхөн олговор авах шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа 3 жил байна. Хөөн хэлэлцэх хугацааг тоолохдоо Иргэний хуулийн (BGB) ерөнхий журмыг баримтална.

Дээрх процессын дагуу шинжээч хөлсөө авах бол хэрэг хянан шийдвэрлэгдэж дууссаны дараа тухайн зардлыг ХБНГУ-ын ИХШХШТХ-ийн 91-100 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн зардлыг хуваарилж зохигчоор нөхөн төлүүлнэ.

Хэсгийн дүгнэлт: ХБНГУ-ийн хууль тогтоомжид манай улсад тулгамдаж буй асуудлууд болон манай улсын хууль тогтоомжид тусгагдаагүй зүйлсийг дараах байдлаар маш нарийн тусгаж өгсөн байна. Үүнд:

1. Шүүхийн зардлыг хуваарилахдаа ерөнхий зарчмаас гадна, тусгайлсан маргааны төрөл дээр нэхэмжлэгч, хариуцагч талуудад ялгамжтай байдлаар хуваарилахаар хуульчилсан байна.
2. Шүүхийн зардлаас чөлөөлөх, хэсэгчлэн төлүүлэх хүсэлтийг хангах, татгалзах үндэслэлийн тухайд:

Төлбөрийн чадваргүй байдлыг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас тухайн хүсэлт гаргагчийн сард төлсөн татвар, цалин хөлсний мэдээллийг авч үүнээс тооцоолол хийж, 1 сард хүсэлт гаргагчийн төлөх боломжтой хэмжээг тодорхойлдог. Үүнээсээ үнийн тааз тавьсан ба 4 сарын нийлбэрээс шүүхийн зардлын хэмжээ бага байвал туслалцаа олгохгүй байхаар маш нарийн зохицуулсан нь хүсэлт гаргагчийн санхүүгийн хувьд ачаалал өгөхүйц, үнийн дүн ихтэй шүүхийн зардалд туслалцаа үзүүлж байна. Мөн хөнгөмсгөөр, үндэслэлгүйгээр шинжээч томилуулахаар оролдсон тохиолдолд хүсэлтээс шүүх татгалзах эрхтэйг хуульчилсан.

3. Шүүхийн зардлыг талуудын төлөх үе шат, нөхцөл, шинжээч, орчуулагч, гэрч, иргэдийн төлөөлөгчид хөлсөө авах процессын хугацаа, бүрдүүлэх баримт бичиг зэргийг нарийвчлан зааж өгсөн нь тодорхой, ойлгомжтой байна. Шүүхийн зардлыг төлөх процесс дахь “Шүүхийн касс” гэх ойлголт нь Монгол Улсын хувьд шинэ ойлголт байна.

3.2. Бүгд найрамдах казахстан улсын зохицуулалт

БНКУ-ын Иргэний процессын хууль нь 2015 оны 10 дугаар сарын 31-нд батлагдаж, 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон бөгөөд нийт 54 бүлэгтэй, 504 зүйл заалтаас бүрдэнэ. Тус хуулийн 8 дугаар бүлэгт шүүхийн зардлыг зохицуулсан.

Энэхүү хуулийн 102 дугаар зүйлд шүүхийн зардлыг “Шүүхийн зардал нь улсын тэмдэгтийн хураамж болон хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой зардлыг хэлнэ.” гэжээ. 103 дугаар зүйлд улсын тэмдэгтийн хураамж, 104 дүгээр зүйлд нэхэмжлэлийн үнэ, 105 дугаар зүйлд улсын тэмдэгтийн хураамжийг нэмэлтээр төлөх, 106 дугаар зүйлд улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хойшлуулах, 107 дугаар зүйлд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох талаар зохицуулсан бол 108 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой зардал, 109 дүгээр зүйлд шүүхийн зардлыг хуваарилах, 110 дугаар зүйлд гэрч, шинжээч, орчуулагчид олгох төлбөрийн хэмжээ, 111 дүгээр зүйлд төлбөр олгох, 112 дугаар зүйлд үнэгүй хууль зүйн туслалцаа үзүүлэх, 113 дугаар зүйлд төлөөлөгчийн туслалцааны зардлын нөхөн төлбөр, 114 дүгээр зүйлд хэрэг удаашруулсантай холбоотой хохирлыг нөхөн төлүүлэх, 115 дугаар зүйлд нэхэмжлэлээс татгалзах, эвлэрлийн гэрээ байгуулах, зуучлалын журмаас маргаан шийдвэрлэх үед шүүхийн зардлыг хуваарилах, 116, 117 дугаар зүйлд шүүхийн зардлыг хуваарилах талаар тус тус зохицуулжээ.

3.2.1. Шүүхийн зардал

БНГУ-ын Иргэний процессын хуулийн 102 дугаар зүйлд “Шүүхийн зардал нь улсын тэмдэгтийн хураамж болон хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой зардлыг хэлнэ.” заажээ. Тус хуулийн 108 дугаар зүйлд шүүн таслах ажиллагаатай холбоотой зардалд дараах зардлуудыг хуульчилсан байна. Үүнд:

- гэрч, шинжээчийн зардал;
- газар дээр үзлэг хийхтэй холбоотой зардал;
- нотлох баримт хадгалах зардал;
- хариуцагч, хүүхэд эрэн сурвалжлахтай холбоотой зардал;
- хэргийн талаарх мэдээллийг нийтлэх, зарлахтай холбоотой зардал;
- шүүхэд дуудах, мэдэгдэх зардал;
- зорчих, байрлах зардал;
- төлөөлөгчийн үйлчилгээ авсны /өмгөөлөл/ зардал;
- бусад нөхөн төлөх зардал.

3.2.2. Шүүхийн зардлын хэмжээг тодорхойлох

110 дугаар зүйл. Шинжээч, мэргэжилтэн, гэрч, орчуулагчид олгох төлбөрийн хэмжээ

- Гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагчид шүүхэд ирсэнтэй холбоотой гарсан замын зардал, байрны хөлс харин албан томилолтоор ажиллаж буй этгээдэд тогтоосон хэмжээгээр хоолны зардал, байрны хөлсийг нөхөн төлнө. Шинжээч, мэргэжилтэнд мөн даалгасан ажлыг гүйцэтгэх явцад зарцуулсан химийн урвалж, бусад хэрэглэгдэхүүн материалын зардал, тоног төхөөрөмж ашигласны төлбөр болон ашиглалтын зардлыг мөн нөхөн төлнө.
- Гэрчээр дуудагдсан ажилтны шүүхэд байх хугацаанд нь үндсэн ажлынх нь цалинг хэвээр хадгална. Ажил хөдөлмөр эрхэлдэггүй гэрчид тухайн хугацаанд хийж байсан үйл ажиллагаанаас тасалдсан нөхцөлийг харгалзан, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд үндэслэн нөхөн олгоно.
- Шинжээч, мэргэжилтэн нэг удаагийн үндсэн дээр татагдан оролцож, өөрийн үндсэн үүрэгт хамаарахгүй ажил гүйцэтгэсэн тохиолдолд уг ажлын хөлсийг шүүхийн нэрийн өмнөөс төлнө. Төлбөрийн хэмжээг талуудтай тохиролцон шүүх тогтоож, уг төлбөрийг хүсэлт гаргасан тал урьдчилан хуульд заасан журмын дагуу нээгдсэн дансанд шилжүүлнэ.
- Гэрч, шинжээч, мэргэжилтэнд төлөх төлбөр болон шүүх шинжилгээний байгууллагаар шинжилгээ хийлгэх зардлыг хүсэлт гаргасан тал төлнө. Хэрэв хүсэлтийг хоёр тал хамтран гаргасан, эсхүл шүүхийн санаачилгаар томилсон бол талууд тэнцүү хэмжээгээр төлнө.
- Шүүх шинжилгээний байгууллагад төлөх төлбөрийг урьдчилан холбогдох төсөвт шилжүүлнэ. Хэрэв тогтоосон хугацаанд төлөөгүй бол зардлыг тухайн этгээдэд хэргийн үр дүнгээс үл хамааран, энэхүү хуулийн 109 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт заасны дагуу ногдуулна.
- Талууд шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн тохиолдолд шинжээч, мэргэжилтэнд олгох төлбөрийг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр хэргийг шийдвэрлэсний дараа төсвийн хөрөнгөөс олгоно.
- Шинжээч, мэргэжилтэнд төлбөр төлөх журмыг Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар тогтооно.⁴⁷

⁴⁷ Kazakhstan, Civil Procedure Code, Article 110.

3.2.3. Шүүхийн зардлаас чөлөөлөх

Энэ талаар 112 дугаар зүйлд заасан. Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэлтгэж буй эсвэл хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгч дараах этгээдүүдийг хууль зүйн туслалцааны төлбөр болон төлөөлөлтэй холбоотой зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлж, уг зардлыг төсвийн хөрөнгөөс гаргах үүрэгтэй.

- Тэжээн тэтгэгчээ алдсаны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх маргааны нэхэмжлэгч;
- Хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэж байх үед эрүүл мэндэд хохирол учирсан, эсвэл гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх маргааны нэхэмжлэгч;
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоогүй маргаанд оролцож буй Эх орны дайны оролцогчид, тэдгээртэй адилтгах этгээдүүд, хугацаат цэргийн албан хаагчид, I болон II бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр насны тэтгэвэр авагчид (нэхэмжлэгч ба хариуцагч);
- Хуулийн дагуу цагаатгагдсан, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргаж буй этгээд;
- Өмгөөлөгчийн үзүүлсэн хууль зүйн туслалцааны хөлс болон төлөөлөлтэй холбоотой зардлын хэмжээг БНКУ-ын Засгийн газар тогтооно. Төлбөр хийх журмыг БНКУ-ын Хууль зүйн яамнаас баталсан журам баримтлан хэрэгжүүлнэ;

Туслалцаа авах хүсэлт гаргагч нь улсын төсвийн хөрөнгөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэйг нотлох баримт бичгийг хүсэлтдээ хавсаргана.

Шүүх хүсэлтийг хангах эсвэл татгалзах тухай шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрт бие даан гомдол гаргах, прокурорын хүсэлтээр хянах боломжгүй. Тухайн шийдвэрийг зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ үндсэн хэргийн давж заалдах гомдолд тусгаж болно.

Шүүхийн шийдвэрийг тухайн орон нутгийн Өмгөөлөгчдийн зөвлөлд нэн даруй хүргүүлэх бөгөөд тус зөвлөл шүүхээс тогтоосон хугацаанд өмгөөлөгчийн оролцоог хангах үүрэгтэй.⁴⁸

113 дугаар зүйл. Төлөөлөгчийн туслалцаа авсны зардлыг нөхөн төлөх.

Шүүх ялсан талын хүсэлтээр, процессын явцад туслалцаа үзүүлсэн төлөөлөгчийн зардлыг бодитоор гарсан хэмжээгээр эсрэг талаас гаргуулна.

⁴⁸ Kazakhstan, Civil Procedure Code, Article 112.

- Мөнгөн нэхэмжлэл бүхий маргаанд: Зардлын хэмжээ нь нэхэмжлэлийн хангагдсан шаардлагын 10 хувиас хэтрэхгүй байна.
- Эд хөрөнгийн бус нэхэмжлэл бүхий маргаанд: Зардлын хэмжээ нь боломжит хязгаарт байх боловч 300 сарын тооцооны индексээс (МРП) хэтрэхгүй байна.
- Хэрэв төсвийн хөрөнгөөр мэргэжлийн хууль зүйн туслалцаа авсан тал ялсан бол уг зардлыг улсын төсөвт нөхөн төлүүлнэ.⁴⁹

МРП буюу сарын тооцооны индекс гэдэг нь БНКУ-ын эдийн засаг, эрх зүйн зохицуулалтын суурь үзүүлэлт бөгөөд инфляцын түвшин болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчилдэг үзүүлэлт юм.

БНКУ-ын Төсвийн хуулийн 3 дугаар зүйлийн 34 дэх хэсэгт МРП-г “тэтгэмж болон бусад нийгмийн төлбөрүүдийг тооцох, мөн хууль тогтоомжийн дагуу торгууль, татвар болон бусад төлбөрийг тооцоход ашигладаг коэффициент” гэж албан ёсоор тодорхойлсон байдаг.

Хүснэгт 3.7 МРП-ийн хэмжээ болон Монгол төгрөгийн харьцуулалт

Он	1 МРП-ийн хэмжээ Тенге	Монгол төгрөг
2023	3450 KZT	26500 ₮
2024	3692 KZT	28400 ₮
2025	3932 KZT	30200 ₮

Эх сурвалж: Бүгд Найрамдах Казахстан Улсын 2023 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн № 43-VIII "2024-2026 оны улсын төсвийн тухай" хууль. "Әділет" эрх зүйн мэдээллийн систем. [Цахим эх сурвалж]. URL: <https://adilet.zan.kz/rus/docs/Z2300000043>

3.2.4. Шүүхийн зардлыг хуваарилах

- Энэ талаар 109 дүгээр зүйлд заасан. Нэхэмжлэл хангагдсан тохиолдолд хариуцагч шүүхийн зардлыг бүхэлд нь хариуцна. Нэхэмжлэлийг хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн тохиолдолд шүүхийн зардлыг нэхэмжлэгчид хангагдсан хэсэгт харгалзах хувь хэмжээгээр, хариуцагчид нэхэмжлэлийн хангагдаагүй хэсэгт харгалзах хувь хэмжээгээр тус тус ногдуулна.
- Хэрэгт оролцогч этгээд хууль буюу гэрээгээр тогтоосон нэхэмжлэл гаргахын өмнөх буюу маргаан шийдвэрлэх урьдчилсан журмыг зөрчсөний улмаас маргаан үүссэн буюу хариу тайлбараа хугацаандаа өгөхгүй байх, хариу өгөхөөс татгалзах, шүүхээс гадуурх

⁴⁹ Kazakhstan, Civil Procedure Code, Article 113.

маргаан шийдвэрлэх журмыг зөрчих зэргийг хэлнэ. Энэ тохиолдолд тухайн этгээдэд шүүхийн зардлыг хэргийн шийдвэрээс үл хамааран ногдуулна.

- Мөн шүүх нь процессын эрхээ урвуулан ашигласан, эсхүл процессын үүргээ биелүүлээгүй этгээдэд /шүүхээс тогтоосон хугацаа зөрчих гэх мэт/ шүүхийн зардлыг бүхэлд нь ногдуулах эрхтэй бөгөөд энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулсан, саатуулсан, эсхүл хууль ёсны, үндэслэл бүхий шийдвэр гаргахад саад учруулсан тохиолдолд хамаарна.
- Давж заалдах болон хяналтын шатны шүүхүүд шийдвэрийг өөрчилсөн, эсхүл хэргийг дахин хэлэлцүүлэхгүйгээр шинэ шийдвэр гаргасан тохиолдолд холбогдох шатанд гарсан зардлын нотлох баримтыг тал гаргаж өгсөн бол шүүхийн зардлын хуваарилалтыг өөрчилнө.
- Давж заалдах болон хяналтын шатанд гарсан шүүхийн зардлыг гаргуулах тухай хүсэлтийг тухайн шатанд хэлэлцсэн боловч нотлох баримтын үнэн зөвийг шалгах шаардлагын улмаас шийдвэрлээгүй бол анхан шатны шүүх энэ талаар шийдвэр гаргана.
- Шүүхийн зардлыг гаргуулах тухай хүсэлтийг талуудад мэдэгдэн шүүх хуралдаанаар хэлэлцэнэ. Талууд зохих ёсоор мэдэгдсэн боловч ирээгүй нь хүсэлтийг хэлэлцэхэд саад болохгүй. Хүсэлтийг шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш нэг сарын дотор гаргаж болно.
- Төлөөлөгчийн үйлчилгээний зардлыг нөхөн төлүүлсэн шүүхийн шийдвэрийн хувийг тухайн төлөөлөгчийн бүртгэлтэй татварын байгууллагад (иргэн бол оршин суугаа газар, хуулийн этгээд бол байршлаар) ажлын тав хоногийн дотор хүргүүлнэ.⁵⁰

Гэрч, шинжээч, орчуулагчид төлбөр төлөх- 111 дүгээр зүйлд заасан:

1. Гэрч, шинжээч болон мэргэжилтэнд төлөх зохих төлбөрийг тэдгээр нь үүргээ гүйцэтгэж дууссаны дараа Бүгд Найрамдах Казахстан Улсын төсвийн хууль тогтоомжийн дагуу нээгдсэн данснаас шүүх төлнө.
2. Орчуулагчид төлөх төлбөрийг Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газраас тогтоосон журмын дагуу улсын төсвийн хөрөнгөөс гаргана.⁵¹

⁵⁰ Kazakhstan, Civil Procedure Code, Article 109.

⁵¹ Kazakhstan, Civil Procedure Code, Article 111.

3.2.5. Шүүхийн зардал төлөх процесс

БНКУ-ын хувьд шинжээч томилуулах хүсэлт гаргасан тал шинжээчийн зардлыг шүүхийн түр дансанд урьдчилан байршуулдаг. Шүүхийн түр данс нь шүүхээс томилогдсон шинжээчид төлөх төлбөрийг талуудаас урьдчилан авч, ажил гүйцэтгэж дуусах хүртэл уг дансанд хадгалагдаж, шинжээчийн дүгнэлтийг шүүхэд ирүүлсэн үед шүүхээс тухайн шинжээчийн данс руу хөлсийг төлөхөд зориулагдсан данс юм.

БНКУ-ын Сангийн сайдын 2014 оны №540 тушаалаар батлагдсан "Төсвийн гүйцэтгэл ба түүний кассын үйлчилгээний журам"-ын 451 дүгээр хэсэгт “шүүхийн түр данс нь хууль тогтоомжид заасан тодорхой нөхцөл бүрдэх үед холбогдох этгээдэд буцаан олгох эсвэл зориулалтын дагуу шилжүүлэх хүртэлх хугацаанд төрийн байгууллагын (шүүхийн) мэдэлд түр хугацаагаар байршиж буй мөнгөн хөрөнгийг бүртгэхэд зориулагдсан.” гэжээ.

Уг данс нь шинжээч, мэргэжилтнийг томилсны дараа талууд төлбөрөө төлөхгүй байх, эсвэл шинжээчийн дүгнэлт таалагдаагүй тохиолдолд мөнгөө төлөхөөс татгалзах эрсдэлээс сэргийлдэг ба нөгөө талаас шинжээчийн хөлсийг шинжээчид шууд өгөхгүйгээр шүүхийн дансанд тушааснаар шинжээч талуудаас эдийн засгийн хараат бус ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг гэж үздэг.

БНКУ-ын Иргэний процессын хуулийн 110 дугаар зүйлийн 110.3 дахь хэсэгт шинжээч томилуулах хүсэлт гаргасан тал шүүхийн түр дансанд шинжээчийн хөлсийг урьдчилан байршуулахаар зохицуулсан. Мөн 2006 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн №9 дугаартай БНКУ-ын Дээд шүүхийн “ О судебной практике применения законодательства о судебных расходах по гражданским делам” буюу “ Иргэний процессын хууль дахь шүүхийн зардлыг практикт хэрэгжүүлэх талаар” тогтоол гаргасан. Уг тогтоолын 12 дахь хэсэгт “шинжээчийн хөлсийг шүүхийн түр дансанд урьдчилан байршуулахдаа тухайн хүсэлтийг гаргасан тал нь хөдөлмөрийн хөлсний хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хэмжээнд үндэслэн хөлсийг шүүхийн түр дансанд байршуулна.” гэж заажээ.

БНКУ-ын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн зардлыг дээр дурдсанчлан шинжээч томилуулах хүсэлт гаргасан тал шинжээчийн зардлыг урьдчилан шүүхийн түр данс руу мөнгөн хөрөнгийг байршуулсны даруу шүүгч үүн дээр үндэслэн шинжээч томилох захирамж гаргадаг. БНКУ-ын Засгийн газрын 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн № 601 тогтоолоор “Шинжээч, мэргэжилтэн болон орчуулагчид төлөх төлбөрийн журам батлах тухай” тогтоолын дагуу шинжээч, мэргэжилтэн, орчуулагч нь

үүргээ гүйцэтгэж дууссаны дараа тухайн этгээд нь шүүхийн захиргааны асуудал эрхэлсэн төрийн байгууллагын санхүүгийн албанд дараах баримт бичгийг бүрдүүлэн хүсэлт гаргана:

- Үйлчилгээний төлбөрийг олгох тухай шүүгчийн акт;
- "Цахим засгийн газар" порталаас авсан иргэний үнэмлэхийн хуулбар;
- Банкны харилцах дансны дугаар.

Санхүүгийн алба нь шүүхийн актыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хянана. Хяналт хийж дууссаны дараа санхүүгийн алба нь шүүхийн түр данснаас төлбөрийг нэн даруй шилжүүлнэ.

Хэрэг хянан шийдвэрлэгдэж дууссаны дараа БНКУ-ын Иргэний процессын хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу шүүхийн зардлыг хуваарилж, зохигчоор нөхөн төлүүлнэ.

Хэсгийн дүгнэлт: БНКУ-ын хувьд ХБНГУ-тай төстэй бөгөөд хүсэлт гаргасан талаар шинжээчийн зардлыг урьдчилан шүүхийн түр данс руу шилжүүлдэг, уг процессыг БНКУ-ын Дээд шүүхийн тогтоол, Засгийн газрын тогтоолоор нарийвчлан зохицуулсан буюу шүүхийн зардлын бие даасан хууль байхгүй бөгөөд процессын хуульдаа тэдгээрийг бүгдийг шингээжээ. Шинжээч томилох шүүгчийн захирамж нь хүсэлт гаргасан тал нь шинжээчийн хөлсийг урьдчилан шүүхийн түр дансанд мөнгөн хөрөнгө байршуулсны үндсэн дээр гардаг. Энэ нь мөн шинжээчид эдийн засгийн баталгааг өгч байна. Нөгөө талаас шинжээчийг хараат бус байлгахад чиглэгдсэн байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын ИХШХШтХ-д шинжээчийн зардлыг практикт хүсэлт гаргасан тал урьдчилан төлөх хандлага байгаа хэдий ч энэ талаар хуульчилсан зүйл байхгүй байна. Шинжээч нь шинжээчийн хөлсөө нөхөн авах процесс тодорхойгүй байна. Бодит байдал дээр барилгын ажил гүйцэтгэх гэрээ болон программ хангамж, апп бүтээх ажлын шинжээчийн зардал хэт өндөр гардаг байдлаас шалтгаалан талууд шинжээчийн зардлыг төлөхгүй удаашруулах хүсэл зоригоос хамаарч, төрөөс санхүүжүүлэх шаардлага гардаг. Хэдий хуульд улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан ч тухайн үед төсөв байх эсэх нь эргэлзээтэй. Шүүгчийн туслах, болон ахлах нягтлан бодогч нараас авсан судалгааны үр дүнд хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй тохиолдолд шүүхээс шинжээчийн зардлыг ИХШХШтХ-ийн 52 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.1, 55.2 дахь хэсгийн дагуу шүүх төлдөг ч шүүхийн зардлын дүн мэдээнээс харахад нийт зардалд ногдох шинжээч, орчуулагч хэлмэрчийн зардал нь 0,3 хувийг эзэлдэг нь маш бага бөгөөд төлбөрийн чадваргүй иргэд, хуулийн этгээдийн хүсэлт хангагдах нөхцөл хязгаарлагдмал байна. Практикт шүүхийн зардлаас чөлөөлөх нөхцөлийг хангасан, бага үнийн дүнтэй шүүхийн зардлыг төсвөөс гаргадаг. Гэтэл дээр дурдсанчлан өндөр үнийн дүнтэй, төлбөрийн чадваргүй гэдгээ нотолдоггүй улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлсэн хэвээр буюу шинжээчийн зардлаа төлөөгүйн улмаас ажиллагаа 1,2 жил зогссон хэрэг хэвийн үзэгдэл болоод байна.

Нөгөө талаас шинжээчийн хувьд шинжээчийн хөлсөө авах процесс хууль, дүрэм журмаар нарийвчлан зохицуулагдаагүй байгаа нь хийсэн ажлынхаа хөлсийг авахад хүндрэлтэй байдаг учраас шинжээчид дүгнэлтээ гарсны дараа зардлаа тооцож, эхлээд шинжээчийн зардлыг авсны дараа дүгнэлтийг шүүхэд ирүүлдэг нь мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах бүрэлдэхүүн болж байна.

Харьцуулсан судалгаа хийсэн хоёр улсын хууль тогтоомжид ХБНГУ-ын хувьд шүүхийн зардлаас чөлөөлөгдөх, хэсэгчлэн төлөх хүсэлтийг хангахад тавигдах урьдчилсан нөхцөлүүд процессын хуульд маш нарийн зохицуулсан ба, тухайн хүний төлбөрийн чадваргүйг хуульд заасан тооцоолол хийж өндөр үнийн дүнтэйгээс гадна хүсэлт гаргагчийн орлогоос сард гарч болох зардлуудыг хасаж үлдэх орлогыг 4 дэх нэмэгдүүлсэн үнийн дүнтэй, түүнээс дээш шүүхийн зардлын хувьд 48 сар хүртэлх хугацаагаар хэсэгчлэн төлүүлэх, сарын үлдэх орлого нь 10 еврогоос бага тохиолдолд шүүхийн зардлаас чөлөөлөх

хүсэлт хангагддаг нь Монгол Улсаас ялгаатай байна. Шүүхийн зардлаас чөлөөлөх, хэсэгчлэн төлөхөөс бусад тохиолд “Шүүхийн касс” гэх тусгай дансанд хүсэлт гаргасан тал шүүхийн зардлыг төлсний дараагаар шинжээч томилуулах шүүгчийн захирамж гаргадаг ба, данс руу шилжүүлэх хугацаанд хийгээгүй нь шинжээч томилуулах хүсэлтийг татгалзах үндэслэл болж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн, шуурхай удаашралгүй явуулахад чиглэгдэж байна. Энэ зарчмаар хүсэлт гаргасан талаас урьдчилан гаргуулж, хэрэг маргаан хянан шийдвэрлэсний дараа шүүхийн зардлыг хуваарилах зарчмын дагуу ялагдсан тал нөхөн төлнө. Мөн шинжээчийн хувьд нь хөлсөө авах процесс нь нарийвчилсан хуулиараа нарийн зохицуулсан. Процессын хувьд шинжээч дүгнэлтээ захирамжид заасан хугацааны дагуу шүүхэд ирүүлдэг. Үүн дээр үндэслэж шинжээчийн зардлаа авах эрх нь үүсдэг. Шинжээчийн хувьд ажлын хөлсөө аль талаар гаргуулах нь чухал биш, хамгийн гол нь ажлынхаа хөлсийг авах нь чухал. Тиймээс шинжээчийн зардлыг урьдчилан тооцоолж шүүхийн кассад хийсэн нь эдийн засгийн баталгааг бий болгож байгаа нь дүгнэлтээ шүүхэд ирүүлэх хөшүүрэг болж өгч байна. Харин талуудын хувьд шүүхийн зардлыг нөхөн гаргуулахтай холбоотой тусгайлсан процесс явагддаг. Энэ нь шинжээчийн зардлаас гадна хуульд заасан бусад шүүхийн зардлыг нэгтгэн нийт шүүхийн зардлын үнийн дүнг шүүхийн зардлыг төлүүлэх гэж буй тал баримтаар нотлох замаар шүүхийн зардлын үнийн дүнг тогтоох ажиллагаа явагддаг.

БНКУ-ын хувьд шинжээчийн зардлыг ХБНГУ-тай ижил “Шүүхийн түр данс” гэх дансанд хүсэлт гаргасан тал шүүхийн зардлыг заавал төлөх ба төлсний дараагаар шинжээч томилуулдаг байна. БНКУ-ын хууль тогтоомжид шүүхийн зардлаас илүүтэйгээр төлбөрийн чадваргүй хүнд хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах талаар нарийн зохицуулсан байна. Гэрч, шинжээчийн зардлыг урьдчилан шүүхийн түр дансанд төлүүлэх процесс явагддаг бол орчуулагчийн зардлыг шүүхээс санхүүжүүлдэг. Орчуулагчийн зардлын тухайд Монгол Улстай ижил байна. Гэрчийн зардлын хувьд заавал талуудаар гаргуулдаг ба гэрч ажил, хөдөлмөр эрхэлдэг тохиолдолд тухайн өдрийн цалин хөлсний хэмжээгээр, ажил хөдөлмөр эрхэлдэггүй тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр зардлыг тооцож түр данс руу гэрч дуудах хүсэлт гаргагч зардлыг төлдөг. Шинжээч хөлсөө авахдаа бүрдүүлэх баримт бичиг, хандах байгууллага, түүний хүсэлтийг шийдвэрлэх хугацааг нь тодорхойлж өгсөн байна. ХБНГУ-тай харьцуулахад шүүхийн зардалтай холбоотой асуудлыг процессын хуулиас гадна, Монгол Улстай ижил эрх бүхий байгууллагаас гаргасан журмаар зохицуулж байгаа нь хялбар, ойлгомжтой байна.

Эцэст нь дүгнэхэд, Монгол Улсад шүүхийн зардлаас чөлөөлөх, хэсэгчлэн төлөх тухайд ХБНГУ-ын зохицуулалтыг оруулах. Харин шинжээчийн зардлын тухайд хоёр улсад хэрэглэгдэж буй шүүхийн түр данс, тусгайлсан дансыг нэвтрүүлэх. Шинжээч хөлсөө авах процессын тухайд БНКУ-ын зохицуулалт нь шинжээч дүгнэлтээ шүүхэд ирүүлсний дараа шүүхийн санхүүгийн албанд бүрдүүлэх баримт бичгийн хамтаар хөлсөө авах хүсэлт гаргадаг бөгөөд 10 хоногийн дотор шийдвэрлэдэг нь хялбар, түргэн шуурхай учир нэвтрүүлэх боломжтой байна. ХБНГУ-ын хувьд хэрэг хянан шийдвэрлэгдэж буй шүүхэд хөлсөө авах хүсэлтээ гаргах нь цаг хугацааны хувьд удаан. ХБНГУ нь шүүхийн зардлыг тооцох, төлүүлэх тусгайлсан процесс явагддаг нь хэрэг хянан шийдвэрлэгдэх нийт хугацаа удаан байх нөхцөлийг бүрдүүлдэг болзошгүй бөгөөд Монгол Улсын хувьд заавал тусгай процесс явуулах хэрэгцээ шаардлага байхгүй гэж үзэж байгаа тул шинжээч хөлсөө авах, шүүхийн зардлын хэмжээг тодорхойлоход БНКУ-ын зохицуулалтыг нэвтрүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

САНАЛ

Судлаачийн хувьд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн зардлын зохицуулалтад дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Шүүхийн зардлыг хүсэлт гаргасан талуудаас урьдчилан авч харьцуулсан хоёр улстай ижил “шүүхийн тусгай данс” нээх. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулахгүй, шинжээч, мэргэжилтнийг томилсны дараа талууд төлбөрөө төлөхгүй байх, эсвэл шинжээчийн дүгнэлт таалагдаагүй тохиолдолд мөнгөө төлөхөөс татгалзах эрсдэлээс сэргийлнэ.
2. Шүүхийн зардлаас чөлөөлөх, хэсэгчлэн төлүүлэх хүсэлтийг шийдвэрлэхдээ ХБНГУ-ын хууль тогтоомжид заасан шиг хүсэлт гаргагчийн цалин дээр үндэслэн тооцоолол хийж, шүүхийн зардлыг хэсэгчлэн төлөх доод үнийн хэмжээ, хэсэгчлэн төлөх дээд хугацааг, мөн зардлаас чөлөөлөгдөх тааз үнийн дүнг тогтоох. Энэ нь хүсэлт гаргагчийн хувьд санхүүгийн дарамт үүсэхээс сэргийлэх, шаардлагатай хүнд туслалцаа үзүүлэхэд үр дүнтэй бөгөөд шүүхийн зардлаас чөлөөлөх, хэсэгчлэн төлүүлэх ойлголтыг салгаж өгнө.
3. Шинжээч хөлсөө авах процессын хувьд БНКУ-ын хууль тогтоомжид тусгасны дагуу шинжээч нь дүгнэлтээ ирүүлсэн дараагаар шүүхийн санхүүгийн албанд шаардлагатай баримт бичгийн хамт хүсэлт гаргах нь хялбар, цаг хугацааны хувьд түргэн шуурхай, нөгөө талаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах нөхцөл байдлыг буруулах боломжтой гэсэн саналтай байна.

Дээрх саналуудыг БНКУ шиг процессын хуульдаа шингээх нь Монгол Улсын хувьд тохиромжтой байна. Ингэхдээ ХБНГУ-д зохицуулсан шүүхийн зардлаас чөлөөлөх, хэсэгчлэн төлөх, шинжээч, хэлмэрч, орчуулагч, гэрч, иргэдийн төлөөлөгч хөлсөө авах процессыг зохицуулалтаар баяжуулах хэрэгцээ шаардлага байна.

НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эрх сурвалж:

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он.
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
3. Сангийн сайд, 2024 оны 04 сарын 01-ний А/52 дугаар тушаал, *Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай.*
4. Сангийн сайд, 2025 оны 01 сарын 03-ны А/3 дугаар тушаал, *Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам.* -
5. Шүүхийн ерөнхий зөвлөл, 2020 оны 05 сарын 20-ны 63 дугаар тогтоол, *Автомашинны шатахуун зарцуулалтын норм тогтоох тухай.*
6. Шүүхийн ерөнхий зөвлөл, 2024 оны 10 сарын 24-ны 238 дугаар тогтоол, *Шүүхийн төсвийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам.*
7. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Сангийн сайдын хамтарсан тушаал, 2022 оны 01 сарын 07-ны 6/А3 дугаар тогтоол, *Шүүхийн иргэдийн төлөөлөгчид хөлс болон албан томилолт, замын зардал олгох журам.*
8. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, 2012 он.
9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Адилбишийн Эрдэнэцогт, *Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй*, 3 дахь хэвлэл, 2022 он
2. БНМАУ-ын Шүүх яам, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хуулиуд, 1980 он.
3. Буриадын Лхагварагчаа, Пүрэвийн Эрдэнэбаатар, Алгаагийн Дэлгэрбаяр, *Эрүүгийн процессын эрх зүй -Ерөнхий, тусгай анги*, 2024 он
4. Загдын Мөнхжаргал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Ерөнхий анги, 2009 он.
5. Загдын Мөнхжаргал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Ерөнхий анги, 4 дэх хэвлэл, 2013 он.
6. Монгол улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 2 дахь хэвлэл, 2008 он.
7. Монгол улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 2 дахь хэвлэл, 2008 он.

8. Монгол Улсын Дээд шүүх, Монголын шүүх, Хууль тогтоомжийн эмхтгэл, үүх, Хууль тогтоомжийн эмхтгэл, Нэгдүгээр хэсэг, 2016 он
9. Монгол Улсын Дээд шүүх, Монголын шүүх, Хууль тогтоомжийн эмхтгэл, үүх, Түүхэн хөгжлийн тойм, Өгүүлэл нийтлэл Хоёрдугаа хэсэг, 2016 он
10. Монгол Улсын Хууль Зүйн яам, *Монгол Улсын хуулиуд* 2, 1995 он.
11. Содовсүрэнгийн Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2 дахь хэвлэл, 2008 он.
12. Шүүхийн ерөнхий зөвлөл, *Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал*, 2023 он.
13. Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэн, *Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргах, түүнийг үнэлэх асуудал*, 2015 он

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээр:

1. Code of Civil Procedure. (n.d.). https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html
2. Civil Procedure Code of Kazakhstan (PDF file). <https://www.acerislaw.com/wp-content/uploads/2021/11/Civil-Procedure-Code-Kazakhstan.pdf>
3. Ministry of Justice of the Republic of Kazakhstan. (n.d.). *On approval of the rules for the payment of amounts due to experts, specialists and interpreters*. Retrieved from <https://adilet.zan.kz/>

Б. Герман хэл дээр:

1. Bundesministerium der Justiz. (n.d.). *Gesetz über die Vergütung von Sachverständigen, Dolmetscherinnen und Dolmetschern sowie Übersetzerinnen und Übersetzern (JVEG)*. Retrieved from <https://www.gesetze-im-internet.de/>
2. Bundesministerium der Justiz. (n.d.). *Gerichtskostengesetz (GKG)*. Retrieved from <https://www.gesetze-im-internet.de/gkg/>
3. Bundesministerium der Justiz. (n.d.). § 17 GKG – Einzelnorm. Retrieved from https://www.gesetze-im-internet.de/gkg/_17.html
4. Bundesgerichtshof. (n.d.). *Gesetz zur Modernisierung des Kostenrechts (Kostenrechtsmodernisierungsgesetz – KostRMoG)*. Retrieved from <https://www.bundesgerichtshof.de/>

В. Орос хэл дээр:

1. Республика Казахстан. (n.d.). *О применении судами законодательства о судебных расходах по гражданским делам*. Retrieved from <https://adilet.zan.kz/>

4. Цахим эх сурвалж:

1. Бүгд Найрамдах Казахстан улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем:
<https://adilet.zan.kz/>
2. Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас: <https://judcouncil.mn/>
3. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>
4. Холбооны Бүгд Найрамдах Герман улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем:
https://www.bmjbv.de/DE/Startseite/Startseite_node.html